

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ҮГИЙГ МЭДЭГДЭХҮҮН МЭДЭХҮҮН БА
ХЭЛЭГДЭХҮҮН ХЭЛЭХҮҮНИЙ ТАЛААС ҮЗЭХ НЬ

М. Базаррагчаа¹

Б. Мөнгөнцэцэг²

*Хэлний нэгжсийн гадаад орчин нь нэг
нөхцөлд дотоод орчин нь болж, нөгөө
нөхцөлд гадаад орчин нь болно.*

Ш.Лувсанвандан

Хэлэнд агуулга ба гаргалгын тал бүхий эх, өгүүлбэр, үг, бүтээвэр гэсэн үндсэн нэгжүүд байдаг. Хэлний дээд, доод түвшин, тэдгээрийн нэгжүүдийн багтах, багтаах эрэмбэ дэс нь тухайн хэлний нэгжүүдийн хувьд шаталсан тогтолцоог бүрдүүлнэ. Эдгээр нэгжүүд нь үүрэг мөн чанараараа бие биеэ нөхөхийн зэрэгцээ бие биетэйгээ эсрэгцэн, дээд түвшний нэгж нь доод түвшнийхээ нэгжийг багтааж, доод түвшний нэгж нь урвуугаар дээд түвшнийхээ нэгжид багтдаг байна. Хэлний нэгжүүд ийнхүү давхарлан шаталсан тогтолцоог үүсгэхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байна. Энэ нь хэлний нэгжүүдийн ижилсэх ба ондооших ёстой нөхцөлдөж байдаг. Хэлний нэгжүүдийн хоорондох утгын гол харьцааг

ойролцоо нэгж-----эсрэг нэгж
⋮
төсөөт нэгж-----зүйлчилсэн нэгж

хэмээн загварчилсан байна. (М.Баз., Ж.Бая.-1997 (1998), 58-63-р т.)

Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахан даруй танигдана. (Д. Нацагдорж) “Хэдэн жижиг юм түүний дунд сүүмэлзэхийг яахан даруй танина” гэсэн хоёр өгүүлбэр нь ойролцоо өгүүлбэр болох бөгөөд эхний өгүүлбэрт “надад/бидэнд”, дараагийн өгүүлбэрт “би/бид” гэсэн эрхэн үйлдэгч нь тэг гишүүн болох ба энэ хоёр ойролцоо өгүүлбэр нь бодит үйл явдлын хувьд нэг учраас бодит ойролцоо өгүүлбэр болно. Хийсвэр ойролцоо өгүүлбэрийг “танигдах”-ыг “мэдэгдэх, ойлгогдох (гадарлах, төсөөлөх)” гэж сольж харьцуулан гаргаж болно. Ийнхүү ойролцоо нэгж нь үг төдийгүй бусад нэгжид байх ба И.М.Кобозевагийн үзсэнээр тэдгээрийг юмжуулах (бодит) ба дохиожуулах (хийсвэр) гэсэн хоёр талаас үзэж болно.

Ойролцоо нэгж нь тэмдэглэхүүн нь өөр, тэмдэглэгдэхүүн нь адил (ойр) байдаг бол ижил нэгж (омономия) нь тэмдэглэхүүн нь нэг, тэмдэглэгдэхүүн нь өөр байдаг. Үүгээрээ энэ хоёр нэгж нь өөр хоорондоо эсрэг тэсрэг шинжтэй юм. Гэтэл тухайн үгс нь тэмдэглэхүүн ба тэмдэглэгдэхүүний хувьд хагас тохирч, мөн хагас ялгарч буйг

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.


² “Гурван Эрдэнэ” дээд сургууль.

төсөөт үг гэх ба монгол хэлний төсөөт үг нь ойролцоо ба эсрэг, зүйлчилсэн ба салаа утга үүсгэдэг онцлогтой юм. (Б.Ид.- 2005, 3-17-р т.) Иймд төсөөт ба ойролцоо үгийг нарийн ялгахад төвөгтэй юм.

Ойролцоо үгсийн утгын холбоо нь төсөөт үгсийг бодвол утгаараа адилсах нь илүү бөгөөд тогтолцоот шинж давамгайлж байдаг. Үүнд:

		агуулга	гаргалга
1	ижил үг	утгын ялгаатай	ижил
2	олон утга	олон ухагдахууны утгын холбоотой	адил
3	ойролцоо утга	ерөнхий утгаараа ижил	ялгаатай (ижил бус)
4	төсөөт утга	Дээрх гурван харьцааг өөртөө багтаана.	
		утгын хамааралтай	төсөөтэй

О.Д. Прокопчик ойролцоо ба төсөөт үгийн талаар “Төсөөт үг нь нэг талаас ижил үг ба салаа утга хоёрын хооронд, нөгөө талаас, ижил үг ба ойролцоо үгсийн хооронд “савлаж” байдаг үзэгдэл юм. Үүнд тэдгээрийн холбоог



гэж загварчлаад, гаргалгын хувьд ойролцоо үгс нь авиатайгаа утгын холбогдолгүй бол төсөөт үгс нь авиатайгаа зайлшгүй холбогдолтой болох юм. Мөн ойролцоо үгс нь утгаараа адил ба нэг эхийн дотор солих боломжтой, өөр өөр эхэд солих боломжгүй тул хааяа нэг нь нөгөөгөө орлож болох бөгөөд эдгээрийг толь бичигт адил утгаар тайлдаг бол төсөөт үг нь ерөнхий утгатай тул хэлэхийн явцад утгын ялгараа нь саармагшиж тэдгээр нь хутгалдахад хүрдэг. Иймд адил эхийн дотор төсөөт үгийг солих тухай тодорхой ярьж болно. (О.Д.Про.-2005, стр. 47) гэж үзсэн байна.

Ю.Д.Апресян ойролцоо үгсийг нэг үгсийн аймагт багтаан үздэг бол О.Д. Прокопчикийн үзсэнээр, төсөөт үгс нь өөр өөр үгсийн аймагт багтаж болох ажээ. Жишээ нь: *weak* (A):*weakness* (N), *wool* (N):*wooler* (A), *whose* (A):*who* (Pr), *bracth* (N):*bracthe* (V)³ (сул:сул шинж, ноос:ноослог, хэн:хэний) (Энэ тухай хожим дурдах болно).

Ойролцоо үгийн талаарх монгол хэл судлаачдын саналыг дараах байдлаар ялган үзэж болмоор байна. Үүнд:

1. Олонхи судлаачид, тухайлбал, Ш. Лувсанвандан⁴, М. Гаадамба⁵, Т. Пагва⁶,

³ А-тэмдэг нэр, N-жинхэнэ нэр, V-үйл үг, Pr-төлөөний үг

⁴ Ш.Лувсанвандан. Аливаа хэлэнд дуудлага харилцан өөр боловч утгын талаар ойролцоо үгсийг ...утга ойр үгс гэнэ. (Ш.Лув.-1939, 152-р т.) ...дуудлагаараа өөр боловч утгаараа төсөөтэй буюу нэн ойр үгс байдгийг хэлшинжлэлд ойролцоо үгс гэж нэрлэдэг. (Ш.Лув.- 1951, 125-р т.) Дуудлага нь харилцан өөр боловч утгын талаар харилцан ойр бүхий үгс тохиолдох бөгөөд тийм үгсийг хооронд нь зохих байдалд солин хэрэглэхэд утга санаа төдий гуйвдаггүй аж. Жишээлбэл, “удаанлаажим явах” гэхэд утга санаа төдий л алдагдан өөр болох явдалгүй. (Ш.Лув.-1962, 502-503-р т.)

⁵ М.Гаадамба. Ойролцоо утгатай үгийг синоним гэнэ. Утгаараа ойролцоо боловч яг адилтгаж болохгүй үгс...(М.Гаа.-1958, 94-р т.)

⁶ Т.Пагва. Синонимын тухай ердийн тодорхойлолт нь дуудлага өөр боловч утга ойролцоо буюу адил үгсийг хэлнэ. (Т. Паг.-1959, 99-р т.)

Ц.Өлзийхутаг⁷, Ж.Төмөрцэрэн⁸, Д.Отгонсүрэн⁹, Б.Сумьяабаатар¹⁰, Д.Бадамдорж¹¹, С.Байгальсайхан¹² нар ойролцоо үгийг “дуудлага өөр, утгаараа төсөөтэй буюу нэн ойр үг” хэмээн санал нэгтгэйгээр тодорхойлж байна. Нэг хэсэг эрдэмтэд ойролцоо үгийг утгын хувьд “адил буюу ойролцоо” гэсэн байхад зарим нь зөвхөн “ойролцоо, төстэй” гэж үзсэн хоёр хандлага ажиглагдаж байна.

2.С.Дулам, Ц.Хасбаатар¹³ “утгын талаар ижил буюу төстэй байж, маш нарийн ялгарах үгс”, Ш.Гаадамба¹⁴ “утгын буюу найруулгын өнгө аясын нарийн ялгаа бүхий үгс”, Д.Галбаатар¹⁵ “өөр хоорондоо маш нарийн утгын ялгаатай бүлэг үгс”, Ц.Сүхбаатар “найруулгын болон утгын өнгө ялгараатай нэрлэж байгаа өөр өөр үг” хэмээн үзсэн нь ялангуяа найруулгад ойролцоо үгийн утгын болон найруулгын өнгө ялгараа чухал болохыг онцлон тодорхойлсон байна.

3.Ц.Сүхбаатар¹⁶ “нэг ухагдахууныг...нэрлэж байгаа”, П.Бямбасан¹⁷ “нэг ухагдахуун илэрхийлэх”, Г.Галбаяр¹⁸ “ямар нэг ухагдахууныг найруулгын болон утгын өнгө ялгаруулан нэрлэх” хэмээн тодорхойлсон нь хийсвэр утга буюу хэлэгдэхүүний талаас үзсэнтэй холбогдож байна. Үүнээс гадна П.Бямбасан багш “Нэг юм, үзэгдэл, шинж, үйл байдлыг тэмдэглэсэн” гэсэн нь бодит утга буюу мэдэгдэхүүний талтай холбогдоно.

⁷ Ц.Өлзийхутаг. Дуудлага нь харилцан өөр боловч утга нь хоорондоо ойролцоо үгс байдаг. Ийм үгсийг ойролцоо үг гэнэ. (Ц.Өл.-1968, (1979) 39-р т.)

⁸ Ж.Төмөрцэрэн. Дуудлагаараа өөр өөр боловч утгаараа харилцан нэг буюу ойр байдаг үгсийг ойролцоо нэр гэдэг. (Ж.Төм.-1964, 21-р т.) Дуудлага өөр боловч утга адил буюу ойролцоо үгнүүд байдаг. Түүнийг утга ижил үг гэнэ. (Ж.Төм.-1974, 35-р т.)

⁹ Д.Отгонсүрэн. Синоним гэдэг нь яг адилгүй боловч ойролцоо утга илэрхийлэх хэлний арга хэрэглүүр юм...Авианы бүтэц дуудлагаар ялгаатай боловч ойролцоо утга илэрхийлэх үгсийг үгийн сангийн ерийн синоним гэнэ. (Д.От.-1975, 72-73-р т.) Бүтэц дуудлагаараа ялгаатай боловч утгаараа ойролцоо үгсийг ойролцоо утгат үгс гэнэ. (Д.От.-1984, 38-р т.)

¹⁰ Б.Сумьяабаатар. ...дуудлагаараа өөр боловч утгаараа төсөөтэй буюу нэн ойр үгс байдгийг хэл шинжлэлд ойролцоо үгс гэж нэрлэдэг. (Б.Сумь.-1986, 125-р т.)

¹¹ Д.Бадамдорж. Ойролцоо утгат үг гэдэг бол дуудлага, бичлэгээрээ өөр, утгаараа ойролцоо хийгээд тун адилхан үгс юм. (Д.Бад.-1997, 106-р т.)

¹² С.Байгальсайхан. Ойролцоо нэр. Дуудлага, бичлэгээрээ ялгаатай боловч, ойролцоо ижил утгыг заан нэрлэдэг үгсийг хэлдэг. (С.Бай.-1995, 94-р т.)

¹³ С.Дулам, Ц.Хасбаатар. Дуудлагаараа ялгаатай боловч мөн нэгэн ойлголт тэмдэглэж, утгын талаар ижил буюу төстэй байж, маш нарийн ялгарах үгсийг ойролцоо нэр гэдэг. (С.Дул., Ц.Хас.-1980, 138-р т.)

¹⁴ Ш.Гаадамба. Утга, найруулгын зэрэг ямар нэг талаараа ойролцоо боловч яг адил биш, утгын буюу найруулгын өнгө аясын нарийн ялгаа бүхий үгсийг ойролцоо утгатай үг гэнэ. (Ш.Гаа.-1989, 114-р т.)

¹⁵ Д.Галбаатар. Дуудлагаараа ялгаатай боловч нэг ойлголтыг тэмдэглэж, утгаараа ижил буюу ойролцоо байхын хамт өөр хоорондоо маш нарийн утгын ялгаатай бүлэг үгсийг ойролцоо үг гэнэ. (Д.Гал.-2002, 193-р т.)

¹⁶ Ц.Сүхбаатар. Ойролцоо утгат үг гэдэг нь нэг ухагдахууныг найруулгын болон утгын өнгө ялгараатай нэрлэж байгаа өөр өөр үгийг хэлдэг. (Ц.Сүх.-1988, 98-р т.)

¹⁷ П.Бямбасан. Нэг юм, үзэгдэл, шинж, үйл байдлыг тэмдэглэсэн нэг ухагдахуун илэрхийлэх, үгсийн нэг аймагт холбогдох ойролцоо буюу адил утгатай, үгсийн сангийн биеэ даасан нэгжүүдийг синоним гэж болно. (П.Бям.-2006, 361-р т.)

¹⁸ Г.Галбаяр. Ойролцоо утгат үг гэж ямар нэг ухагдахууныг найруулгын болон утгын өнгө ялгаруулан нэрлэхдээ ойролцоо юм уу, ижил утгыг заадаг дуудлага, бичлэгээрээ ялгаатай өөр өөр үгсийг хэлдэг. (Г.Гал.-2002, 86-р т.)

4.П.Бямбасан багш “үгсийн нэг аймагт холбогдох... үгсийн сангийн биеэ даасан нэгж”, Ж.Бат Ирээдүй¹⁹ “үгийн нэгэн аймгийн ойролцоо утга бүхий...үгс” хэмээн тодорхойлсон нь Ю.Д.Апресяны “ойролцоо үг нь нэг үгсийн ай(маг)-д багтсан байна” (Ю.Д.Ап.-1974, стр. 221-224) гэж үзсэнтэй таарч байна.

Б.Сумьяабаатар “Нуураа чи хөлдөх гээд байна уу даа хө

Нугас гэдэг амьтан хөөрхий болно доо хө

Нууцгай ханилсан чи бид хоёр хө

Арга ч үгүй амраг мөнөөс мөн үү дээ хө...

Далай чи хөлдөх гээд байна уу даа хө

Загас гэдэг амьтан хөөрхий болно доо хө

Далдуур ханилсан чи бид хоёр хө

Арга ч үгүй амраг мөнөөс мөн үү дээ хө

гэдэг. Энэ хоёр бадгийн утга нь адил, юугаараа ялгаатай байна гэвэл, нэгдүгээр мөрийн “нуур”, “далай”, хоёрдугаар мөрийн “нугас”, “загас”, гуравдугаар мөрийн “нууцгай”, “далдуур” гэдэг үг л ондоон бусад нь ижил байгаагаас бидэнд хамгийн сонирхолтой нь “нууц”, “далд” гэдэг үг байна. Энэ нь бидний яриад байгаа ойролцоо үг маань юм.” (Б.Сумь.-1966, 6-р т.) гэжээ.

Г.И.Рамстедт 1935 оны “Халимаг толь”-доо монгол хэлний ойролцоо үгсийг “syn.” гэсэн тэмдэглээний дор жагсаасан байдаг. Жишээ нь: *итгэх-сүжиглэх-шүтэх-үнэмших* (p.211), *исгэх-ээдрэх-бээх-гашилах* (p.211), *ирмэх-жумийх-жалмайх* (ирмэх чирмэх) (p.210), *им чим, ив чив* (p.208), *ээрэх-томох-төмөх-имрэх* (p.208), *яг-таг-лаг* (p.218), *яльгүй-бичкён* (p.214), *ялд унагаах-буруутгах-ялд орох-ял авах* (p.211), *ялайгаад суух-таглайгаад суух* (p.218), *ялах-ял авах* (p.218), *ялан-дан* (p.214), *янхайх-ялдайх-ханхайх* (p.215), *янхар-янхгар* (p.215), *явших-яниших-ярих-чалчих* (p.217), *ёгт-жэжиг* (p.219), *ёлхойх-шолхойх-шалхийх-шалбайх* (p.219), *ёлхойх-ёлбойх* (p.219), *ёдгоч-ёргоч-ёрч* (p.219), *ёргоч-ёдгоч-сэжигч* (p.219), *давхар-давтах* (p.71), *дэлбэгэр-задгай-далбагар-далгар* (p.75), *тан-дан хийх* (p.76), *давших-дамжих* (p.81), *шат-давиуур* (p.81), *дэв-дув хийх* (p.84), *дэгдрэх-дэвдрэх* (p.84), *эгц-дэгц* (p.85), *дэвхцэх-дэвхээдэх* (p.89), *дэрдэгнэх-дэр дэр хийх* (p.89), *дэржигнэх-дэр дэр хийх* (p.89), *дээшлэх-босох* (p.91), *долдаалах-хөлбөрөх-долдойх* (p.94), *долийх-дөлийх* (p.94), *доших-дөших-төших* (p.97), *дөхөх-дөмөх-дөнөх-дөнгөх* (p.98), *дөших-төших-тоших* (p.100), *дунгар-дунгараан-дугараан* (p.102), *дуржигнах-дур дур гэх* (p.103), *дутуу-татуу* (p.104), *дүрвэлзэх-дурвалзах-дарвалзах* (p.106) зэргийг дурдаж болох ба үүнд ихэвчлэн авиа ба дүрс дуурайх үг багтжээ. Харин авиа ба дүрс дуурайх үгс нь төсөөт үг болно.

Монгол хэл шинжээчид ойролцоо үгийн судалгааг зохих хэмжээгээр хийж ирсэн боловч ихэнх нь дайвар шинжтэй байна. Харин эрдэмтэн Ж. Бат-Ирээдүй “Монгол хэлний ойролцоо утгат үг, хэллэгийн бүтэц, утга, үүргийн судалгаа” гэсэн сэдвээр бие даасан судалгааг хийсэн. Тэрээр уг бүтээлдээ ойролцоо үгийн бүтэц, утгыг нарийвчлан судалж, улмаар хэлний үндсэн үүргийг тодорхойлсон бөгөөд ойролцоо үгийн өвөрмөц онцлогийг олон талаар нээн үзүүлэхийг зорьж, ойролцоо үгийн онолын судалгаанд шууд хамаарах ойролцоо, адил чанарын онцлог, ойролцоо үгийн эгнээний онцлог, утга, хэрэглээний онцлогийг жишээ баримтаар батлахыг чухалчилсан байна. “Ойролцоо үгийг бүтээгч хосууд нь заавал нэг үгийн аймагт багтана” гээд үгийн аймаг тус бүрийн

¹⁹ Ж.Бат Ирээдүй. Ойролцоо үг нь үгийн сан-утга зүйн хувьд аль нэг хэсгээрээ адил ойролцоо харьцаанд хамаарах үгийн нэгэн аймгийн ойролцоо утга бүхий, хэлэнд нэгэнт хэвшин тогтсон үгс. (Ж.Бат.-1998, 64-р т.)

ойролцоо утга бүтээх чадамжийг авч үзсэн байна. Заримаас дурдвал, “Монгол хэлэнд тооны нэрс ойролцоо үгс бүтээдэг гэж үзэж болохоор байна. Гэхдээ үүнийг бүх тооны нэрэнд хавтгайруулан ойлгож болохгүй. Жишээлбэл, *хоёр хос, нэг ганц, арван мянга түм, зуун мянга бум* гэх мэтээр цөөн боловч ойролцоо утгатай тооны үг монгол хэлэнд байж байна. ...Монголчуудын мал аж ахуйн соёл иргэншилтэй холбогдож мал амьтны тухайт үг (уриат үг) ойролцоо утгатай байж болно гэж үзэж байна. Энэ үгс нь хэдийгээр мал амьтанд өөр өөр боловч дуудах, ирүүлэх, хөөх туух утгаараа ойролцоо юм. Жишээлбэл, дуудах утгатай *хөөр хөөр, зуу зуу, тоор тоор, гөлөг гөлөг, гуры гуры*; хөөх утгатай *хөж хөж, чүү чүү, чаа чаа, дөж дөж, жов* зэрэг үгс байна. ... Төлөөний үг язгуур, үндсийн олон хувилбартай байдаг ч утгаараа ойролцоо байж болно. Тухайлбал, биеийн төлөөний үг: *би, миний, намайг, надаас, надаар, надтай, надад, мань*; *чи, та, чиний, таны...өдийд, одоо, төдийд, тэр үед* гэх мэт. ...сэтгэлийн олон талт шинж чанар тэмдгийг олон талаас нь олон янзаар илэрхийлдэг учир ойролцоо утгатай үгийг бүрдүүлнэ. Тухайлбал, халууныг мэдэрсэн аялга *халхай халхай, халцгай халцгай*; чамлаж зэмлэсэн утгатай *ээ чааваас, ээ хөөрхий, ээ балар*; баярласан утгатай *урай урай, гоёо гоёо, гялай гялай, уухай уухай, зөв зөв, зүйтэй, ай даа, яг* гэх мэт үгс ойролцоо утгыг бүрдүүлнэ.” (Ж.Бат.-1998, 53-54) гэжээ. Харин “*ганц*” гэдэг нь тооны утгатай тэмдгийн нэр болох ба хүн малын тухайт үгс хэмээн нэрлүүлэгч нь чухамдаа бүтэц бус өгүүлбэр болно. Мөн биеийн төлөөний үгийн хувилал буюу нөхвөрийг болон “*өдий төдий*” гэх мэт төсөөт үгийг ойролцоо үг гэж болохгүй юм. Тэрээр, ойролцоо үгийн онцлогийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1-рт, үгийн сан утга зүйн хувьд:

- a. Ойролцоо үгийн эгнээ буюу үүр нь үгийн сан утга зүйн нэг бүлэгт хамаарна.
- b. Ойролцоо үгийг бүрдүүлэгч үүрийн үгс утгын хувьд ойролцоо боловч хэлэнд оршин тогтнож байна.

2-рт, хэлний зүйн хувьд:

- a. Ойролцоо үгийн хос, үүр үг нь бүгд нэг үгийн аймагт багтана.
- b. Үгийн бүтцийн хувьд үүсмэл биш байж болно.
- c. Үгийн сангийн бүтцийн хувьд үгээр, холбоо үгээр байж харилцан ойролцоо утга илтгэж болно.

3-рт, үүргийн хувьд:

- a. Ойролцоо үг нь бие биеийг хэрэгтэй газар орлох үүрэгтэй. Энэ бол ойролцоо үгийн хамгийн чухал үүрэг.
- b. Үгийн утгын нарийн ялгааг илэрхийлэх боломжийг бүрдүүлж өгдөг.
- c. Хэлний хэрэглээний явцад нэг хос нь сэтгэхүйд байнга бэлэн байж байдаг.
- d. Нэг үгийг олон давтахаас зайлсхийх нөхцөл болдог зэрэг шинжүүд болно.

(Ж.Бат.-1998, 65-р т.) Эдгээрийн 1-ийн “б” нь ойлгомжгүй, 2-ын “б”-д дурдсан “Үгийн бүтцийн хувьд үүсмэл биш байж болно.” гэдэг нь монгол хэлний ойролцоо үгс ямагт үүсмэл байдаг” гэсэн үг үү. Ю.Д.Апресян “*бодать-бодаться*” гэж тохицолт бүтээврээр ялгарсан, “*замолкнуть-смолкнуть-умолкнуть*” гэж угтвараар ялгарсан, “*сбить-шибить, сопроводать-сопутствовать*” гэж тохицолт дагавраар ялгарсан байвал эдгээрийг ойролцоо үг хэмээн үзжээ (Ю.Д.Ап.-1974, стр. 227-229) Монгол хэлний а) *дууриа-л* (үлгэр жишээ) *дууриа-лга, дууриа-мал*; б) *дуу-д-, дуу-д-лага, дуу-л-аач, дуу-л-гч, дуу-л-л, дуу-л-га-вар, дуу-л-гар, дуу-ль, дуу-рь, дуу-рх-г, дуу-рь-лиг, дуу-рь-с-, дуу-рь-с-л, дуу-т, дуу-ч-н, дуу-ш-*” зэрэг үгс нь ойролцоо үгс болох уу. (Энэ тухай ойролцоо ба төсөөт үг, салаалбарын тухай зүйлээс хойно үзнэ үү)

Монгол хэлний ойролцоо үгийг хэл, хэлэхийн талаас ялгасан ба хэлэхүйн буюу эх сэдвийн ойролцоо утгат үгийг “үгийн сангийн утгаараа ойролцоо утгатай биш шал өмнөө боловч тухайн сэдвээс хамаарч ойролцоо утгатай гэдэг нь мэдэгдэж байгаа үг” хэмээн тодорхойлоод, монгол ардын дуу “Хөөрхөн халиун”-д

Хөөрхөн халиун долгион шүү

Хөлд нь сууж бариарай

Хүний газар хэцүү шүү

Хүлээн байж дасаарай (МАД:16) гэж үгүүлдэг. Эндээс хөөрхөн халиун гэдэг бол морины зүс боловч морь гэж ямар ч монгол хэлэнд хүний сэтгэхүйд бууж байдаг. Гэтэл гадаадын хүн бол үүнийг ойлгодоггүй. Гэтэл “хөөрхөн халиун гэдэг морь” гэвэл ойлгож чадна. Үүнийг л бид хэлэхүйн ойролцоо үг гэж нэрлэх гээд байгаа юм.” (Ж.Бат.-1998, 114-р т.) гэжээ. Энэ мэт морийг морины өнгө, хэлбэр галбир, явдлаар төлөөлүүлэн хэлсэн хайчин халиун, нарийхан халиун, будал цолмон хүрэн, гөхөл дэлтэй хээр зэрэг нь хэлэхүйн ойролцоо үг биш, харин юмыг шинжээр нь төлөөлүүлэн хэлсэн төлөөлөл буюу синегдоха юм.

Буриад хэлний ойролцоо үгийг Н.Б.Дугаров анх нарийвчлан судлахдаа ойролцоо үгийн талаарх судалгааг гурав хуваан үзсэн байна. Үүнд:

1. Утга нь адил үгсийг ойролцоо утгат үг гэж үзсэн нь Л.Н.Саркисов, А.Д.Григорьева, В.М.Григорян нар ажээ.

2. А.Н.Гвоздев, Р.А.Будагов, Н.С.Валгина, Д.Э.Розенталь, М.И.Фомина, В.В.Цанукевич, Б.Н.Головин нар нэг ухагдахууны ялгааг илтгэх, дуудлагаараа өөр, утгаараа ойр (адил бус) үгсийг ойролцоо үг гэж үзжээ.

3. Е.М.Галкина-Федорук, К.В.Горшкова, Н.М.Шанский, А.В.Калинин, Ю.Д.Апресян нар утгаараа бүрэн ба бүрэн бус тохирох боловч утгын зарим шинжээрээ ялгарах, өгүүлбэрт солих боломжтой, санаа бодлыг нарийвчлах үгсийг ойролцоо үг гэж тодорхойлсон байна. Тэрээр ойролцоо үгийг “Нэг ухагдахууныг тэмдэглэх, утгаар ижил буюу ойр үгс, харин нэг нь нөгөөгөөсөө ялгарсан утга болон найруулгын өнгө аяс, эсвэл энэ хоёрын аль алинаар ялгарах үгс” (Н.Б.Дуг.-1978, стр. 20) хэмээн тодорхойлж, буриад хэлнээ ойролцоо үгс нь

1) Салаа утгаас үүссэн ойролцоо үг (хэхэ (хийх) гэсэн үг нь 7 салаа утгатай бөгөөд жишээлбэл “хэхэ” нь давын өмнө “дархалха, бүтээхэ” (үйлдэх) гэсэн утгатай тул “хийх, бүтээх, дархлах” гэсэн ойролцоо үгс бүтэх ажээ.

2) Дагаврын аргаар бүтэх ойролцоо үгс (ажаглал-ажаглалга)

3) Хэлц үгээр ойролцоо утгас үүсэх (түргэн-нүд цавчих зуур, хол-далан долоон давааны цаана, жаран жалгын эхэнд, хариуцах-хариу өгөх)

4) Ормол үгээр ойролцоо үгс үүснэ. (соёл-культура, тон-маш, хуралдаан-конференци, зохиогч-автор, эмч-доктор, уриа-лоозон)

5) Нутгийн аялгууны үгээр ойролцоо үгс бүтнэ. (отообай-өвгөн аав, шордомхой-давирхайтай, төөдэй-хөгшин ээж, хүүхэн-басхан)


6) Эерүүлсэн үгээр ойролцоо үгс бүтнэ. (“үхэх”-ийг “бусаха, нүгтэхэ, мүнхэрхэ, нойрохо, наһа бараха, мордохо, тагаалал болохо, бурханай орондо яваха, наһаа бараха”, “төрөх”-ийг “марьяажаха, хүндэрхэ, хүл хүндэ болохо, хээлитэй болохо, түрэхэ, хүнгэрхэ, багатай болохо” гэж эерүүлэн хэлдэг ажээ. Мөн “чоно”-ыг “гарюуһан, хээрын нохой, бурханай нохой, унга һүүлтэ, хүйтэн муртэ”, “баавгай”-г “тайгын эзэн, охор һүүлтэ, һилгаанһан гуталта”, “халиун”-ыг уһан тулам”, “булга”-ыг бамбагар, хангилай хэшиг”, “могой”-г “аргамжа, хорхой”, “бүргэд”-ийг ехэ

шүбуун” гэх мэт цээр нэр ч ойролцоо утгыг бүтээнэ.) (Н.Б.Дуг.-1978, стр. 21-36) гэжээ. Тэрээр, ойролцоо үгийг 1. туйлын (*а.хэрэглэл-хэрэглэлээ, хэсэг-хэнэг, б.бороо* (дождь)-хура (дождь), *түрэ* (свадьба)-хурим (свадьба), *в.соёл-культура, г.дурсаха-дурдаха, тус-туд, д.термометр-градусник, врач-доктор*); 2.утгын (идеографические синонимы) (*томо-ехэ-мантан* (мантагар) *халуун-бүгшэн-ааяма, хараха-шагааха-шэртэхэ, морин-агта-хүлэг, холхин-хуй-ураган*) 3.найруулгын (*агсаха-андалдаха, уулзаха-бараалхаха-золгохо, унтаха-нойрсохо-хунхыха, үргөө-байр, шарил-хүүр, бэльеүү нюдэн-хурса нюдэн, номин далай-күкэ далай*) гэж ангилсан (Н.Б.Дуг.-1978, стр. 40-52) ба “бүхэгэр-бүхэтэр, бүлдэгэр-бүлсэгэр-бүлтэгэр, тохигор-тахигар, годигор-гохигор, хотогор-хатигар” зэрэг дүрслэх үгийг ойролцоо үг гэж үзжээ. Эдгээр нь Н.Б.Дугаровын үзсэнээр үгийн хувилбар бус, тодорхой нөхцөлд өөр хоорондоо утга ялгарч, нэг нь хэрэглэгдэх тул ойролцоо үгс болох ажээ. Бидний санавал, эдгээр нь авианы чөлөөт сэлгэцээр үүссэн, нэг үгийн хувилбар болно. Учир нь, авиа ба дүрс дуурайх үгс нь нэг юмын янз бүрийн өчүүхэн шинжийн ялгааг заахаас биш, бие даасан юм ба ухагдахууныг заахгүй юм. Т.А.Бертагаев (авиа ба) дүрс дуурайх үгийн сэлгэмэл авиалбарыг бүрэн бус авиалбар (авианцар=фонемойд) (Т.А.Берт.-1974, стр. 263) гэж үзсэн байдаг. Тэрээр, “*харзай, хэрзий-, хөрзий-, хяргай-, арзай-,өрзай-, иржий-, ярзай-, ёрзой-, барзай-, борзой-, бэржий-, биржий-, бурзай-, бүрзий-, гарзай-, горзой-, зарзай-, зэрзий-, жүржий-, жөржий-, царзай-, цорзой-, цэрзий-, цөргий-, цүрзий-, цүрзай-; марзай-, морзой-, мурзай-, мярзай-; ларзай-, лөрзий-, лорзай-, лэрзий-; сарзай-, шарзай-, сорзой-, шорзой-, шурзай-*” гэхчлэн “-рз” гэсэн хэлц бүтээврээр ижилссэн үгсийг “багц сэлгэвэр” (пучки чередования) (Т.А.Берт.-1969, стр. 96-99) гэж үзсэн нь хам цагийн үүднээс төсөөт үг, цуваа цагийн үүднээс үгийн утга хэлбэр (авиа)-ийн хувилбар юм.

Бодитой ба хийсвэр юмс үзэгдэл, түүний шинж чанар зэргийг заасан, дор бүрнээ салаа утгатай, ойр утгатай нөгөө үгээсээ ялгарах шинж олонтой, бие даасан “*хаалга-үүд, бат-бэх (бөх), салах-хагацах-ангижрах, уур-хилэн-онтуун, ховдог-хомхой-шунахай-шунаг-авилгач*” гэх мэт үгс байх ба “үүд” гэхэд 1.орох гарах хаалга 2.хаалга хавийн газар 3. гараа, үндэс, эхлэл, 4. сэдэх санахын үүднээс (шалтгааны утгатай туслах үг болсон) гэсэн салаа утгатай юм. Харин монгол хэлний авиа ба дүрс дуурайх үг нь салаа утга төдий л гарахгүй, нэг юмын дотоод гадаад шинж, хэлбэр дүрсийг заадаг. Өөрөөр хэлбэл, авианы чөлөөт сэлгэцээр үүссэн авиа ба дүрс дуурайх үгс нь төсөөт үг болно. Хэдийгээр ойролцоо үгийг зөвхөн хам цагийн үүднээс үзэх нь зохистой гэж Ю.Д.Апресян, А.П.Евгеньева нар үздэг боловч “*qobduy-qomuiqai*” хэмээх үгсийн “qob-, qomui-” хоёр нь “-b\~mu”-ийн сэлгэцээр үүссэн тул энэ хоёр үгийн эхний хэсэг нь адил, сүүлчийн хэсэг ондоо болж “алагласан” учраас төсөөт үгс байж болох юм. “*уранхай-ноорхой, онгорхой-цоорхой, хагархай-цоорхой*” зэргийг ч ойролцоо утгат төсөөт үг (Б.Ид.-2005, 11-р т.) гэж болно.

Н.Б.Дугаров өгүүлбэр дотор ойролцоо үгсийн нэгийг нөгөөгөөр солих тухай ялангуяа хийсвэр утга бүхий үгсийн харьцааны хувьд ойролцоо үгс нь янз бүрийн ухагдахууны олон шинж буюу нэг ухагдахууны олон шинжийн алиныг зааж буйг тодорхойлоход хэцүү юм. Тийм үед ойролцоо үгсийн нэгийг нь нөгөөгөөр солих аргыг ашиглах нь чухал юм” (Н.Б.Дуг.-1978, стр. 10) гэжээ. Цаашилбал, тэрээр, “Өөр өөр юмсыг заасан ойролцоо үгсийн үүрийн гишүүдийг солих боломжгүй, солилоо ч гэсэн ихээхэн төвөгтэй юм. Гагцхүү егөөдсөн утгатай үед сольж болох юм. Жишээ нь: *богони-оодон-охтор-навтар-охор-тагтагар-могсогоор-хуумагар*” зэрэг үгийн “*навтар*” нь хүн болоод намхан юманд, “*богони, оодон*” нь хувцсанд, “*тагтагар, могсогоор, хуумагар*” нь хүний эрхтэнд тус тус хэрэглэнэ. Харин “навтар хувцас, оодон

хүн, хуумагач дээл” гэж хэлэхгүй” гэжээ. Иймээс ойролцоо үгийг солих нь ойролцоо үгсийг таних гол хэмжүүр биш гэж А.Б.Шапино, Ю.Д.Апресян, А.П.Евгеньева нарын адилаар үзсэн байна.




С.Ульман “Ойролцоо нэгж нь тодорхой бус учраас түүнээс нарийн судалгаа гарахгүй, харин түүний арга зүйг боловсруулах хэрэгтэй юм” гэж үзэж байсан бол А.И.Смирницкий “Тухайн хэлний гол ба гол бус тогтолцооны алинд ч, бодит ангилалд ч ойролцоо үгсийн үүр бий болохгүй, ер нь үг судлал ойролцоо нэгжийн тухай судлах хэрэггүй юм” гэж үздэг байжээ. Харин Г.Стерн болон Ю.Д. Аapresян нар хэлэн дэх ойролцоо нэгжийг судалж “Ийнхүү ойролцоо нэгжийн эгнээ нь түүхэн явцад бий болсон тогтолцоот шинж бүхий хам цагийн үг хэллэгийг агуулж байдаг” (Л.А.Нов.-1982, стр. 85) гэж үзээд, “Ойролцоо нэгжийг тогтоох шүүлтүүр нь тодорхойгүй, үг хэллэгийн буюу толь бичигт орохуйц ойролцоо утгыг тогтоох оновчтой ямар ч арга байхгүй байгаа нь ойролцоо нэгжийг судлахад ихээхэн төвөг учруулдаг. Гэвч утгын ялгараагаараа, эсвэл найруулгын өнгөөрөө, эсвэл энэ хоёр онцлог шинжээрээ бие биеэсээ ялгарч, нэг ухагдахууныг илтгэж байгаа үгсийг ойролцоо нэгж гэнэ” гэж тодорхойлжээ.

Тэгэхдээ С.Ульман "Ухагдахууны болоод сэтгэл хөдлөлийн утгын өчүүхэн хувиралгүйгээр аль ч эхийн дотор нэгий нь нөгөөгөөр сольж болох ойролцоо үгсийн

тухай ярьж болно” гэж үзээд, зөвхөн тухайн хам цагт а) зарим эхэд сольж болох (*leap-jump, help-aid-assistance*) б) сэтгэл хөдлөлийн утгаар биш, ухагдахууны утгаар сольж болох (*liberty-freedom, hide-conceal*) гэж ангилжээ. Мөн “языкознание –лингвистика” гэхийг туйлын ойролцоо үг, дээрх “сольж болох хоёр төрлийн ойролцоо үгийг “псевдосинонимы” буюу “омоинимы” гэж нэрлэжээ. С.Ульманы энэ санааны дагуу В.А.Звегинцев “юм-ухагдахууны хүрээнд ойролцоо үгийг судлах нь зохимжтой бус, харин хэлэхийн цуваа байрлалд үгсийн утга адилсана” гэж үзсэн нь ойролцоо үгийг мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүний талаас үзэх нь хэлний гадуурх зүйл гэдэгтэй холбогдох ажээ. Тэрээр, “Тэгж үзсэн ойролцоо үгс нь хэв шинжит холбоо үгийн гишүүн нь болно. Ийм холбоо үгс нь дэлгэрэнгүй хэллэг өгүүлбэр зэргийг агуулахгүй юм. Үгийн цуваа бүтцэд үгсийн утга нь адил болох эсэхийг илрүүлдэг хамгийн бага загвар болно” (В.А.Зве.-1963, стр. 137) гээд, орос хэлний “крепкий-прочный-твердый” гэсэн ойролцоо үгсийг янз бүрийн үгсэд холбон дор дорын утгыг гаргажээ. Жишээ нь: “крепкий раствор, крепкий сон, крепкая дружба, крепкий удар, крепкое слово (верное слово, ругательское слово) крепкий сахар” гэх мэтээр холбоо үгсэд утгыг нягталж, хийсвэр ба бодитой ойролцоо үг гэсэн хийсвэр зүйлээс салах болно гэж үзжээ. Тэрээр, ойролцоо үгийг хэмжих хэмжүүр нь холбоо үг гэж үзсэн нь зөвхөн хэлэхүүний талыг харгалзсан байна. Хэрэв ингэж үзвэл, монгол хэлний ойролцоо утгат хоршоо үг нь утгаараа адилсаж, ойролцоо үг бүтэх чухал нэгж болох юм. В.А.Звегинцевийн энэ санааг Л.А.Чешко (Л.А.Чеш.-1968, 1985, стр. 4), А.П.Евгеньева (А.П.Ев.-1966, стр. 16-17) нар эсэргүүцэж, “Ойролцоо үгийн юм болоод ухагдахууны үндсийг авч хаях юм бол түүний хэлний тогтолцоон дахь үгийн нэгжийг нэгтгэж байгаа утгын тал хийгээд цуваа бүтэц дэх хувиргалыг ч ерөнхийд нь үгүйсгэж байгаа хэрэг юм. Ойролцоо үгийн юм ба ухагдахуунт харьцааг арилгах юм бол “хэв шинжийн холбоо үг”-ийн гишүүдийн эсрэгцэх болоод адилсах зохицлыг тайлбарлаж чадахгүйд хүрэх болно. (Л.А.Чеш.-1968(1985), стр. 4) гэсэн ба А.Д.Григорьевагаас “Бидний үзвэл, зөвхөн утгаараа адил болох (ойролцоо утга биш) нь ойролцоо үг болно. Үгийн утга ижилсэхээс бий болох сэтгэл хөдлөлийн өнгө аяс, тухайлбал, эрхэмсэг ба доод найруулга, яруу ба бүдүүлэг найруулга, элдэв найруулгын төрөл зүйл (ярианы ба ном бичгийн, хар ярианы найруулга), хам эхээс үүдэлтэй найруулах онцлог, мөн хэлбэр-хэлзүйн зарим онцлог зэрэг нь утга ижилсэж ойролцоо үгс үүсэхэд саад болохгүй юм” хэмээх үгийг давхар иш татжээ. Мөн А.П.Евгеньева ч В.А.Звегинцевийн дээрх санааны талаар өгүүлэхдээ “Хэрэв “юм ба ухагдахууны харьцаанаас үүдэлтэй утга ойр буюу адил (ижил) болох талыг орхиод зөвхөн утга зохицож адил болохыг ойролцоо үгсийн хэмжүүр гэж онцгойлон үзэх юм бол ойролцоо утгын айд ойролцоо гэмээргүй баахан үгс орж ирэхэд хүрнэ” (А.П.Ев.-1966, стр. 17) гэжээ. Энэ маргаан бол хэлний зогсонги ба хөдлөнги хоёрын заагаас гарсан зүйл ба Р.А.Будагов ойролцоо үгийг нэг талаас, хэлний ба найруулгын тал, нөгөө талаас, ухагдахууны ба найруулбар (стиль) (Р.А.Буд.-1960, стр. 67) гэж ялгасан нь хэлэгдэхүүн ба хэлэхүүн, мэдэгдэхүүн ба мэдэхүүн гэж болно.

В. Гумбольдт “Үг бол тухайн юмыг төлөөлсөн зүйл биш...Харин юмын тухай манай өөрсдийн санаа үзлийн илрэл мөн...Нэгэн ижил зүйлийг олон янзаар илрүүлдгийн гол сурвалж чухам үүнд л байгаа хэрэг. Жишээ нь: Хэрвээ санскрит хэлэнд зааныг хоёр удаа ундлагч гэх буюу хоёр шүдэт, эсвэл гараар зэвсэглэсэн гэх зэргээр нэрлэх нь хэдийгээр нэг юмыг хэлж байгаа боловч эдгээр нэр тус бүрдээ тусгай ухагдахууныг агуулж байна “ (В.Гум.-1964, стр. 102) гэсэн бол, А.А.Реформатский “үүнд

нэг юмын чанарыг элдэв талаас нь өөр өөр нэрээр илэрхийлсэн хэрэг байна.” гэсэн байна. Энэхүү ойролцоо үгийн тухай дээрх саналыг зурагчлан үзүүлэхэд:



Синонимын утга (ухагдахуун) нь ойролцоо буюу адил биш, харин нэрлэж байгаа юм нь адил, ойролцоо байдаг (А.А.Реф.-1955, стр. 62) гэжээ. Энэ нь утгаа бодит утга буюу мэдэгдэхүүний тал, хийсвэр утга буюу хэлэгдэхүүний тал гэсэн нэг юмыг хоёр талаас үзсэнтэй холбогдоно. Ийнхүү ойролцоо үгийн үүслийг В. Гумбольдт хийсвэр утгаас нь, А.А.Реформатский бодитой утгаас тайлбарласан нь үгийн утгын ба үгийн хэлбэрийн үүднээс үзсэнд оршино.

Хэл нь агуулга гаргалга хоёрын шүтэлцээнээс бүтэх ба агуулга нь хоёр янз юм. Хэлний агуулгын нэгжийг агуулбар (семантема) гэнэ. Агуулбар судлал (семантика) нь аливаа бодол санааны үл задрах нийтлэгийг хэлнэ. Үүнийг Луй.Ельмслев агуулгын тал (план содержания) гэдэг. (Луй.Ель.-1960 (1943), стр. 310) Хэлний агуулгаас хэлбэрт шилжүүлэн судалбал нэрлэвэр судлал (ономасиология ономатология) болох ба түүний үндсэн нэгж нь нэрлэвэр (ономаси) юм. Энэхүү нэрлэвэр (нэрлэл) нь үг бүтээврийн утга, үгүүлбэр цогцолборын санаа болж, дөрвөн үндсэн түвшний нэгжүүд болон задарна. Харин Ономатопея²¹ (авиа дуурайх ёс)-гийн нэгжийг дуулгар (ономема) гэнэ.

Хэлний хэлбэрээс агуулгад шилжүүлэн судалбал утга судлал (семасиология) болох бөгөөд түүний үндсэн нэгж нь утгалбар (семема) болно. Нэрлэвэр судлал нь утга судлалаа бодвол хөдлөнги шинжтэй (Е.С.Куб.-1990, стр. 346) юм. Нэрлэвэр судлал нь мэдэгдэхүүний талтай, утга судлал нь хэлэгдэхүүний талтай холбогддог шиг ойролцоо нэгжийн бодитой шинж нь нэрлэвэр, хийсвэр шинж нь утгалбар болно. Ийнхүү хэлний агуулбар судлал нь утгалбар ба нэрлэвэр гэсэн харилцан холбоо бүхий хоёр нэгжтэй юм. Ю.Д.Апресян “Утга нь хэлний утгын тогтолцооны нэгж болно. Энэхүү утга нь янз бүрийн байдлаараа ойролцоо нэгж бүтээдэг бол утгын нарийн ялгаагаараа эсрэгцэж мөн ойролцоо нэгж бүтээдэг. Ойролцоо нэгжийн энэ хоёр эсрэг тал нь хэлэхийн явцад саармагшдаг.” (Ю.Д.Ап.-1957, стр. 88; Ю.Д.Ап.-1974, стр. 241) Жишээ нь: Орос хэлний

²⁰ Ой₁, Ой₂-ондоо ондоо үгс, У₁, У₂-ондоо ондоо ухагдахуун, Ю-нэрлэгдсэн юм нь.

²¹ Ономаси-герег хэлний онома (нэр) хэмээх үгээс үүсэлтэй аж. Энэ томьёог нэрлэвэр (номема) (М.Баз.-1991, 75-р т.)-ээр ойлгож, авиа дуурайх үг (интра-образные слова, ономатопея)-ийг “дуун ухаан” гэдгээс сэдэвлэн “дуу-л-гар” (үг сургамж авах байдал, чих зөөлөн) гэж нэрлэж болох юм. Монголчууд хэл судлалыг “дуун ухаан” гэсэн нь ертөнцийн юм үзэгдэл, тухайлбал, тэдгээрийн дуу чимээг дуурайн хэлтэй болсон гэж үзэж байжээ. “Дуу дуурайх” нь гарал нэг юм. Ш. Лувсанвандан “Юм үзэгдлийг төлөөлсөн хэлний дохио ч мөн тийм байгаа нь чухамдаа байгалийн юм үзэгдлийн үлигэр юм” (Ш.Лу.-1982 (1980), 17-р т.) гэснийг “дуун ухаан” буюу дуулгар (дуурайх) гэж ойлгож болно. “Хүний ухамсар дахь ертөнцийн загвар хэлний бүтэц (адил хэлбэр) хоёр нь Джон Хэйманийхээр бол, “нэг хэлбэр-нэг утга” гэсэн зарчмыг барих болж байна. (И.М.Кобо.-2000, стр. 40) Ономастология, ономасиология (нэрлэвэр судлал), ономастика (нэр зүй) гэж оноон, нэрлэвэр нь “нэрлэгдэхүүн нэрлэхүүн” гэсэн хоёр зүйлтэй байж болох юм.

“смелый” (зүрхтэй, зоригтой, зоримог, аймшиггүй, эрэлхэг), “храбрый” (зүрхтэй, зоригтой, баатарлаг, эрэлхэг) гэсэн ойролцоо үгийн эхнийх нь “идэвхтэй санаачлагч” гэсэн утгатай тул “довтлох, дайрах” утгыг агуулдаг бол эцсийнх нь “хамгаалах, өмгөөлөх” утгатай ажээ. Орос хэлнээ “смелый исследователь” гэж утга шилжүүлж болдог ч “храбрый исследователь” гэж хэлдэггүй. Гэтэл зарим үед энэ хоёр үгийн ялгаа арилж, “Он был храбр и хорошо знал те острые минуты боя, когда командир для решающего хода нужно потушить со смертью” (А. Н. Толстой) гэхэд “храбр” гэхийг “смел” гэж сольж болох ажээ.

Өвлийн дүн хүйтнийг огт тоосон янзгүй ажилчин хүмүүс нааш цааш буужигнаж, хөдөлмөртөө улайраад биднийг нэг их анзаарахгүй байв. (Л. Түдэв. Өнөөгийнхөн, Уб., 1980, 115-р т.) гэхэд “хөдөлмөр” нь “хөдөлж бүтээх”-ийн ерөнхий утга, “ажил” нь (ажиллаж бүтээх)-ийн тодорхой утгаар өөр хоорондоо ялгарах боловч нийлэх утга нь олонх тул “хөдөлмөртөө ажилдаа улайраад...” гэж сольж болно. Энэчлэн “тоо-” нь “сайшаан үзэх, онцлон ялгаж үзэх, тоомсорлох”, “анзаар-” нь “ажиглаж мэдэх, анхаарах” гэсэн утгаар ялгарах боловч “дүн хүйтнийг огт анзаарахгүй” гэж болно. Харин “биднийг нэг их тоохгүй байв” гэвэл “их зан гаргах, хайхрахгүй” утгатай болох тул сольж болохгүй юм. Ийнхүү тухайн эхэд ойролцоо үгс нь саармагшиж, бие биеэ орлож болох авч, ерөнхий утгаараа ойролцоо үгийн эгнээ бүтээвч нэг нь нөгөөгөө орлож үл болох нь ч олон. Жишээ нь: “инээ-” хэмээх үг нь “баярлах, баясах, хөөрөх зэргээс сэтгэл хөдөлж, нүүр нүд, дуу аялгаар илрэх”, “мишээ-” хэмээх үг нь “тааламжтай инээмсэглэх”, “хөхөр-” хэмээх үг нь “тэсэж ядан инээх, инээд алдах” гэсэн утгатай тул дараах өгүүлбэрүүдэд үл саармагших тул сольж болохгүй юм. Үүнд:

1. Гуйланч нарын мах арьс цөм хөлдөж, хагараад, улаан шүүс тавлан гарч, тэсхэл үгүй дагжин чичрэх бөгөөд...хөлдөж үхэхээ баахан ч бодож зовнихгүй инээлцмүй. (В. Инжиннаш)
2. Харь холын мянга түмэн мичид
Өндөр огторгуйн алс хязгаарт мишээж
Түүний дор будант өндөр сүүдэртэхэд
Хааяа нэг манааны адуу янцгаана. (Д. Цэвэгмид)
3. Хөөрхий хадам минь баахан юмны сургаар ходоодоо өлсөж орхив хэмээн эзэн То маасайн хөхөрч... (З. Баттулга) (Р.Жаг.-1976, 81-р т.)

Тэгвэл хэлний ойролцоо байх чанар нь нэг талаас юмтай (денотат), нөгөө талаас утгатай (сигнификат) харьцсан холбоонд үндэслэдэг ажээ. Үгийн утга нь юм үзэгдэлд хандах, мөн хүний ухамсар сэтгэхүйд хандах, үг нь үгэндээ хандах үйлдэлтэй байдгийг утга зүйд тэмдэглэсээр иржээ. Үг нь үгэндээ хандах, үгсийн хоорондын утга зүйн харьцаа зэргийг Ю. С. Степанов “Хэдийгээр учир дутагдалтай ч гэсэн, ойролцоо үгийг утгаараа адил үг хэмээн ихэвчлэн тодорхойлдог билээ. Ойролцоо утга нь ихээхэн нарийн зүйл бөгөөд бүтцийн хувьд юм болоод ухагдахуунд хамаарах гэсэн хоёр хандлага байдгийг би нэгэнт дурдсан болно. Иймээс ойролцоо үгс нь нэг бол ижил юмыг, эсвэл ижил ухагдахуунтай холбоотой юм гэж үзэж болох юм.” гэжээ. (Ю.С.Степ.-1975, стр. 27-30) Ийм ч учраас ойролцоо үгийг юм үзэгдлийн ойролцоо үг, утга ухагдахууны ойролцоо үг гэж ангилсан нь ойролцоо үгийг дотор нь ялган үзэхэд чухал үүрэгтэй юм. Энэ санааны дагуу Б. Идэрбаяр нь ойролцоо үгийг бодит буюу юмжсан ойролцоо нэр, хийсвэр буюу дохиожсон ойролцоо нэр” (Б.Ид.-2005, 10-р т.) гэж ялгасан байна.

Ю.С.Степанов бодитой буюу хийсвэр ойролцоо үгийг мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүний талаас ялгах гэсэн боловч “Нэг ухагдахууны доторх аль нэг шинжээр ялгарах хийсвэр ойролцоо үгс, эсвэл хэд хэдэн ухагдахууныг ялгах олон шинж бүхий бодит ойролцоо үгсийг ангилах нь ямагт бэрхшээлтэй буй нь ойлгомжтой юм.” (Ю.С.Сте.-1975, стр. 32) гэжээ. Тэрээр, бодит утга бүхий ойролцоо үг нь 1) тухайн нэг юмын нэрийг солих, 2) уул юмын тухай ухагдахууны ялгарах зэргээр хийсвэр ойролцоо үгээс ялгарна” гээд орос хэлний *прут* (саваа, шавширга, торлог), *хворостина* (саваа, хатсан бургас, хуурай мөчир), *доза* (ороонго-бургасан саваа, нарийн налархай) гэсэн жишээг бодит ойролцоо үг гэж үзсэн байна. Үүнийг Ю.С.Степанов “нэг юмыг янз янзаар нэрлэх нь түүхэн явцад гарах зүйл” гэжээ. Тэгвэл монгол хэлний

“уламжил-, дамжуул-, мэдэгд-
нигүүлс-, энэр-, өрөвд-
оточ, эмч, доктор
шарил, хүүр, үхдэл
нангиад, иргэн, хятад-доктор
солгой, зүүн, буруу
авла-, агна-, гөрөөл-

ав, ан, гөрөө” (Б.Сум., С.Лу.-1960, 130-р т., 170-р т., 169-р т., 162-р т., 157-р т., 108-р т.) гэсэн ойролцоо үгийн эгнээний эхнийх нь хуучин үгийн шинжтэй тул эдгээр үгс нь бусад үгтэйгээ харьцахдаа бодит ойролцоо үг болох жишээтэй ажээ. Мөн Ю.С.Степановын үзсэнээр, орос хэлний 1) *механизация, механизация, автоматизация*” гэвэл нэг ухагдахууны нарийн утгыг ялган таарч буй хийсвэр ойролцоо үг, 2) *механический, механизированный; механизированный, машинный; автоматический, автоматизированный*” гэвэл нэг юмыг шинэ хуучнаар нэрлэн ялгарч буй тул бодит ойролцоо үг болох аж. Ийнхүү бодит ойролцоо үгс (синонимы по денотату) нь мэдэгдэхүүний талд, хийсвэр ойролцоо үгс (синонимы по сигнификату) нь хэлэгдэхүүний талд тус тус хамаарах юм.

Энэ тухай Б. А. Плотников “Ойролцоо утга ялгаатай болбол тэдгээрийн үүсэх цаг үеийг тооцох хэрэгтэй болно. Жишээ нь, *лобзать-целовать* (озох-үнсэх-таалах), *перет-налец* (хуруу-хуруу) зэрэг үгс нь утгаараа ижил ч үүссэн цагаасаа ялгарч иржээ. Үүнийг түүхэн ойролцоо үг гэж болно” (Б.А.Пло.-1983, стр. 198) гэж өгүүлсэн байдаг.

П.Бямбасан багш монгол хэлний хуучин үгийг мэдэхүүн (прагматика) буюу өнгөн бүтцийн үүднээс 1. өнөөгийн монгол хэлнээ огт хэрэглэгддэггүй, хэл шинжээчид тааварлах төдий мэдэх үгс (*qorči* (*хорч-гүрж улс, хуурч, харваач*) гэдэг үгийг эрдэмтэд хэд хэдэн янзаар таамагласан үгс;

2. Монгол хэлний дурсгалын зүйлд тохиолдох боловч өнөөгийн монгол хэлнээ хэрэглэгддэггүй, зөвхөн мэргэжлийн хүмүүс мэдэх *elbür* (*энхрий, хайрт*) *erke'üd* (*эрхүүд-христос шашины хувраг*), *senshin'üd* (*Диос шашины хувраг хүн*) гэх мэт үгс;


3. Монгол хэлний зарим тольд орсон боловч одоогийн утга зохиолын хэлэнд бараг хэрэглэгддэггүй, өнөөгийн хүмүүст тайлбарлавал ойлгох “*andayar* (*андгай тангараг*), *исал* (*сайн*), *ажин* (*дүү бэр*), *qotiqai quruu* (*долоовор хуруу*), *isa* (*хөө тортог*) гэх мэт үгс;

4. Өмнөх нийгмийн ахуй, шашинтай холбоо бүхий идэвхгүй хэрэглэгдэх, ерийн хүнд ерөнхий утга нь анзаарагдах “*labaja* (*гахайн арьс зэргээр хийсэн хоромсого нумын нэр*), *janggi* (*зуун эрийг нийлүүлж захирсан эр*) зэрэг үгс (П.Бям.-2006 (1969), 330-331-р т.) гэж ангилсан байдаг. Тэгвэл монгол хэлний “цагаа-хүү, мөс-(нумын сум)-сум, тэргүүн-

ЛАВЛАГАА НОМ
МЭДЭЭЛЛИЙН ТАСАГ

- 770 -

- 17 -



толгой, эсгүүр-шүд, гүрэн-улс, лагшин-бие, мэлмий-нүд, сархад-архи, сонор-чих, сүүдэр-нас, сэвлэг-үс, хишиг-өглөг, хүлэг-морь, хөлөг-унаа, шарил-хүүр, эсних-төрөх, цогц-бие, асаах-өмсөх, толилох-анхаарах, үзэх, чилээрхэх-өвдөх, соёрхох-өгөх, таалах-ойшоох, морилох-явах, сонор-чих, мутар-гар (Р.Жаг.-1976, 27-30-р т.), улаан булан-соёлын төв, исэр мухар сандал, алмуур-суга таяг, андалдах-солилцох, дудрай-ядмаг, дорой (Н.Нан.-2005, 115-р т.; Д.От.-1998, 108-110-р т.), анд-найз, нөхөр, жирэн-хоёр, ховчуур (гувчуур)-албан татвар, доёд-бурхны шашины лам, нуган хөвүүн-эрэгтэй хүүхэд (Ж.Төм.-1964, 1974, 99-р т.), улаан гэр, улаан булан-соёлын ордон, хэвтүүл-торгон цэрэг-харуул (Д.Бад.-1997, 200-201-р т.) зэрэг үгс нь Ю.С.Степанов, Б.А.Плотников, Ю.Д.Апресян нарын үзсэн шиг мэдэгдэхүүний үүднээс, нэг юмыг өөр өөрөөр нэрлэсэн бодит ойролцоо үгс (denotation) болох ба энэ нь утгаараа бүрэн тохирох ажээ. А.В.Лагутина туйлын ойролцоо үгийн талаар “Туйлын ойролцоо үгийн үндсэн онцлог нь голцуу нэрлэх ёсноо илэрдэг утгын ижилсэл мэт сэтгэгдэх утгын чанд тэнцэлд оршдог” гэж тодорхойлоод, ийнхүү туйлын ойролцоо үгст найруулгын ялгаа гарахгүй, зөвхөн найруулгын нэг төрөлд багтана. (А.В.Лаг.-1967, стр. 121) гэжээ. Тэрээр туйлын ойролцоо үгс нь нэр томьёо (языкознание-языковедение, гидроксид-гидрат окион, модуль-показатель, лингвистика-языкознание), нутгийн аялгууны үгс (борозняк-заборозняк) –ээс бүтэж болно гэсэн байна. А.В.Лагутина хуучин ба түүхэн үгс нь өнөөгийн утга зохиолын хэлний үгтэй туйлын ойролцоо үг үүсгэх тухай энэ өгүүлэлдээ дурдсангүй. Ю.Д.Апресян унаган үгс нь ормол үгтэй оновчтой ойролцоо үгийг бүтээнэ (Ю.Д.Ап.-1974, стр. 229) гэж үзээд, орос хэлний “аккузатив-винительный падеж, база-фундамент-основа (теории), импорт-ввоз, окулист-глазник, идентичный-тождественный, экспорт-вывоз” зэрэг жишээ татсан байна.

Ийнхүү хуучин ба түүхэн үгс нь өнөөгийн үгстэй ойролцоо утгатай болох талаарх Ю.С.Степановын санал нь Ю.Д.Апресян, А.В.Лагутина нарын саналаас зөрөөтэй байна. Бидний санавал, нэг юмыг өөр өөрөөр нэрлэсэн бодит ойролцоо үгсийг түүхэн ба хуучин үг бүтээх нэг эх булаг болно. А.А.Реформатский орос хэлний “врач-доктор-лекарь-эскулап; аэроплан-самолёт” зэрэг ойролцоо үгнээ “лекарь, аэроплан” зэрэг хуучин үг оролцсон (А.А.Реф.-1967, стр. 93-94) байх ба нөгөө талаас, жирийн үг, хэлц хоёр нь ойролцоо утга бүтээдэг гэж үзвэл, хэлц нь уламжлалт түүхийн шинжтэй байдаг. Жишээ нь: “толхилц-” гэсэн ганцажсан хэлц нь “үг хаялц-, үг сөргөлц-, тар тур хий-, ам муруй-, хамар муруй-” гэсэн нийлсэн хэлцтэй ойролцоо утгатай юм. Харин үүнийг А.А.Реформатский “ам\хамар муруй-” гэх мэтээр ойролцоо бус үг сэлгэх тул хэлц ойролцоо утгыг ангид авч үзэх хэрэгтэй юм гэж үзсэн байна.

Ю. Д. Апресян нар “Утгын ялгаа нь саармагшсан адил үгийг ойролцоо үг гэж болно...Үүний тул, юуны өмнө уул үгсийн утгын бүрэн тайлбар хэрэгтэй болох ба удаад нь, ойролцоо үгийг утга нийлэх нь бус, утга ялгарах нь чухал юм” (Ю.Д.Ап.-1974, стр. 217) хэмээн үзсэн нь ойролцоо үгийг хэлэхийн цуваанд үзэж, тэдгээрийн утгын ялгааг анхаарах хэрэгтэйг тодорхойлжээ. Ю. Д. Апресян ойролцоо утгат үгийг мадаггүй тогтооё гэвэл уул эхийн доторх үгсийг сольж үзэн байж тогтоож болно гэжээ. Тэрээр, энэ тухай “Утгаараа ижил буюу таарч буй үгсийг ойролцоо үг хэмээн хэвшсэн тодорхойлолт нь тайлбарлах хатуу зарчмыг баримтлаагүйгээс хоёр өгүүлбэрийн ойролцоо ба ойролцоо бусыг тогтоочхож чадахгүй юм. Энэ нь үгийн ойролцоо утгыг тайлахад ямагт учир дутагдалтай юм гэж үзсээр ирсэн билээ. Хоёр үгсийн ойролцоо утгыг баримттай тогтоох найдвартай бүрэн ул үндсийг эртнээс хайж ирсэн нь найруулгын болоод бусад боломжоор ялгарах тухайн нэг эхийн дотор утгаараа үл


мэдэг ч ялгаа гарахааргүй ойролцоо утгыг сольж болохуйц тийм байрлалыг гол хэмжүүр болгоход хүрсэн билээ” (Ю.Д.Ап.-1974, стр. 218) гэж өгүүлсэн байна. Ингэж ойролцоо үгийг тухайн өгүүлбэрт солих нь бүрэн ба бүрэн бус гэсэн хоёр янз байж болох ажээ. Жишээ нь:

1. Аливаа	алив	ямарваа, ямар нэг, алимад, хамаг, бүх
2. ер бусын	ер бишийн	гойд, жигтэй, гайхалтай, этгээд, онцгой
3. сонин		хачин, содон, сэвүүн, шинэ, сонирхолтой
4. сайханд		гоё, гоо, үзэмжтэй, үзэсгэлэнтэй
5. нэг		ганц
6. автагдахаараа		автахаараа, дийлдэхээрээ, баригдахаараа, дарагдахаараа
7. өдрийн		огт мартахгүй, Гэгээн өдөр цээжиндээ, харанхуй шөнө
8. бодол		зүүдэндээ; цээжинд хадаатай, цээжний уяа бол-, санаанаас
9. шөнийн		гарахгүй, сэтгэлд хоногш-, дотор таг, толгойд яг
10. зүүд		
11. болгодог		заншилтай, хэвшилтэй, араншинтай, дадалтай, ая зантай
12. зантай		
13. тул	тулд	учирлаас, дээрээс
14. хэдий	хэдийгээр хэдийвээр	
15. бүтэшгүйг		үл бүтэхийг, үл биелэхийг, бүтэх аргагүйг
16. ч	чиг	
17. гэсэн	гэлээ, (гэсэн ч)	
18. мөрөөдөхийн		дурсахын, санахын, хүсэхийн, хүсэмжлэхийн
19. жаргал		цэнгэл, баяр
20. их. (С. Эрдэнэ. Занабазар. Уб., 1989, 119-р т.)		том, аварга

гэхэд солих боломжгүй нь 4, 5, 20-рх үгс байна. Ийнхүү өгүүлбэр дэх гишүүнийг сольж, ойролцоо үг болохыг тогтоох нь нэлээд задгай болж, ойролцоо үгийн эгнээ буюу үүрт хуурмаг ойролцоо үг буюу утга ойр бус, хол үгс багтах болно. Ю.Д. Апресян хуурмаг ойролцоо үгнээ орос хэлний багтсан утга бүхий “*болезнь-саднить*” (өвдөх, өвчлөх, өвчин тусах, өвчин хүрэх-загатнах, хорсох) гэх мэт “төрөл-зүйл”-ийн ойролцоо үг, эс багтсан утга бүхий *жечь-ломить-ныть-резать-саднить-свербеть-сверлить-стрелять* (түлэх – галдах- түймэрдэх - шатаах; нахийлгах-хотойлгох-нугалах; янгинах-шархирах-чимчигнэх; огтлох-таслах-зүсэх-хэрчих-хяргах-даах; загатнах-хорсох-сэрвэгнэх; загатнах-жирвэгнэх; өрөмдөх-нүхлэх-цоолох; буудах-харвах-буу тавих) гэх мэт зүйл- зүйлийн үгсийг багтаасан байдаг. Бидний дээр хүснэгтэлсэн жишээ нь Ю.Д.Апресяны энэ жишээтэй адил байгааг хялбархан ажиглаж болох ба Ю.Д.Апресян 1) бүрэн тохирох ойролцоо үг (А үгийг В үгээр тайлбарлах), 2) өгүүлэхүүнд зохицож буй нэр буюу үйлдэгч нь адил үүрэгтэй байвал ойролцоо үг үүсэх боломжтой. (Орос хэлний “*строить сооружать*” гэсэн хоёр үйл үг нь адил үүрэг бүхий үйлдэгчид болох тул ойролцоо үг болно.), 3) ойролцоо үг нь нэг үгсийн ай(маг)-д багтсан байна (Ю.Д.Ап.-1974, стр. 221-224) гэсэн гурван зүйлээр ойролцоо үгийг тогтоож болно гэж үзсэн байна. Тэрээр үүний эхнийхийг жинхэнэ ойролцоо үг, сүүлчийн хоёрыг хуурмаг ойролцоо үг гэжээ. Ойролцоо үгийн энэ хэмжүүрээр монгол хэлний зарим жишээгээр тайлбарлая. Үүнд:

1. “*өтлөх-хөширөх-өвгөрөх-насжих-зөнөх*” гэсэн ойролцоо үгсийн “*өтлөх*” гэдэг нь гол үг болох ба “*өтлөх*” гэхэд давын өмнө “*хөширөх*” гэдэг үг санаанд буух тул

хамгийн оновчтой ойролцоо үг болно. Харин бусад үгс нь утга холдсон ойролцоо үг болох ажээ. “*өвгөрөх*” гэвэл “*насжих*” хэмээх үг санаанд буух ба “*зөнөх, зөнөглөх, зөнтөх*” гэдэг нь “*өтлөх-хөгширөх*” “*өвгөрөх-насжих*” гэж хос хосоороо бяцхан ялгарсан ойролцоо үгсээс утгын хувьд хол болох бөгөөд эдгээр нь “*мунах, мунхрах, мунаглах, мунхагтах, мунагтах*”, улмаар “*тэнэглэх, тэнэгтэх, тэнэгрэх*” зэрэг “*ухаан санаа будилах самуурах*” гэсэн утгатай үгсээс алслан холдох болно. Энэ мэтээр ойролцоо үгсийг утгын хол ойроор бүлэглэвэл, тэдгээрийн бүтэц буюу хэлэгдэхүүний тал болно. Иймд




гэсэн ойролцоо үгсийн бүтцийг гаргаж болно. Тэгвэл “*шаардуу шавдуу, шаардуу шамдуу, айл аймаг, найр наадам, сайн сайхан, муу муухай, нягт нямбай, сүр сүлд, шавар шавхай, шоолох шоодох, хаах хаших, дэвших дэгжих, гоёх гоодох, хамх хэмх, хага хуга, халт хулт, илүү булуу, олиу солиу, согтуу хөлчүү, бүрий барай, хэмжээ дамжаа, хонхор ёнхор, ус цас, ярзайх ярвайх, алаг булаг, нүл пал, гангар гунгар, унжих санжих*” гэх мэтээр толгой сүүл холбосон хоршоо үг (Б.Рин.-1967, 1-25-р т.), “*амт шимт, хэл ам, хэрүүл шуугиан, яр шарх, яр бэр, гань галзуу, хөл үймээн, сүх мэдга, өвс ногоо, нутаг нуга, мөнгө санга, энх тайван, хувь заяа, нам засаг, мандах бадрах, ядах цөхөх, хахах цацах, өршөөх энэрэх, очих ирэх, арай чарай, шалз ялз, хага хуга, халт мөлт, ховх суга, шалба шалз*” гэх мэт ойролцоо үг (Б.Рин.-1967, 25-33-р т.) гэж төсөөт ба ойролцоо үгийг ялгасхийсэн нь Ю. Д. Апресяны “*бүрэн таарах тайлбар болсон жинхэнэ ойролцоо үг*” гэж үзсэнтэй тохирч байна.

Энэ тухай П.Бямбасан багш ойролцоо үг үүсэх есөн боломжийг тоочсоны дотор “утга нь ойр боловч утгын өнгө нь мэдэгдэхүйц ялгаатай, утгадаа тодорхой ялгарах нэгж (сем)-тэй синонимууд (*айлчин, гийчин, зочин; унтах, нойрсох, дугхийх, зүүрмэглэх, нүдний хор гаргах*), утга нь маш ойр учраас олонх тохиолдолд нэгий нь нөгөөгөөр нь сольж болох боловч зөвхөн валентаараа ялгарах синонимууд (*хил, хязгаар; хашир, хэрсүү*) байх ба “*хил*” гэсэн үг нь “*хилийн харуул, хилийн манаа*” гэж болох боловч “*хязгаар*” хэмээх үг холбогдохгүй, хашир (*хашир тарвага, хашир хүн*) гэж холбогдох авч, хэрсүү тарвага, хэрсүү морь гэхгүй (П. Бям.-2006, 364-365-р т.) хэмээн өгүүлсэн байна. Энэ тухайд Ю.Д.Апресян өгүүлэхдээ “*Утгын болоод бүтээвэр-өгүүлбэрийн зохицол дахь бүрэн тохироо нь “кидатель-бросать, загнать вприпереть к стене, сходный-схожий, везде-всюду, едва - с трудом*” гэх мэт хосолсон ойролцоо үгээр илэрч болох ба чөлөөт шууд утга бүхий ойролцоо үгс байдаг. Голдуу хэлцийн утга бүхий ойролцоо үгс бүрэн тохирох нь нэн ховор. Иймээс үгийн зохицол нь хам цагт аль ч тохиолдолд ихэнхдээ шалтгааны холбогдолгүй юм. Жишээ нь: орос хэлний *беспардонный* (нүүргүй)-*бесзастенчивый* (ичгүүргүй)-*бессовестный* (увайгүй) гэсэн тэмдгийн нэр нь “*ложь (худал хуурмаг)-обман (мэх заль)-вранье (худал үг), лжец (хуурамч), обманщик (мэхлэгч), вран (худалч)*” гэсэн жинхэнэ нэртэй л холбогдоно.” (Ю.Д.Ап.-1974, стр. 231) гэж үзсэн байдаг. Тэрээр ойролцоо үгийг 1.утгын, 2.үгийн, 3.бүтээвэр-өгүүлбэрийн зохицолт ойролцоо үг гэж ялгасан билээ.


П.Бямбасан багш ойролцоо үгс нь утгын өнгө (оттенок-ялгараа (Чой.Лув.-1964, 96, 325-р т.) болон зохицол (валент)-оор ялгах гэж үзсэн нь хам ба цуваа цагийн үүднээс

үзсэн хэрэг бөгөөд энэчлэн, Ю.Д.Апресян “утгын ялгараа” хэмээх нэр томьёо нь хэл шинжлэлийн гурваас зургаан ухагдахуун тэмдэглэдэг. Тэдгээрээс нэг нь утгын онолын олон зүйлд чухал хэрэгтэй болж, үгийн бодит ба хийсвэр утгын онцлог буюу хам бүтэц, утга, үг, бүтээвэр-өгүүлбэрийн зохицол болох цуваа бүтцийн онцлог буюу цуваа бүтцийг илтгэж байдаг (Ю.Д.Ап.-1974, стр. 248) хэмээн үзсэн байна.

Ийнхүү хоёр ойролцоо үгийн утганцар (сема-семантический множитель)-ын ихэнх нь таарвал тэдгээрийн утга нь ойртож, утганцрын ихэнх нь ялгарвал ойролцоо утга нь холдоно. Үүнд “айлчин гийчин зочин” гэхэд нийлэх утганцар нь олон, ялгарах утганцар цөөн, “унтах нойрсох” гэхэд нийлэх утганцар нь олон, ялгарах утганцар нь цөөн болно. “унтах-нойрсох” гэхэд хүндэтгэлийн утгаар ялгарч, бусад шинжээрээ адил болж, харин “хажуулах, дугжрах” гэхэд “түр унтах” гэдгээрээ ойролцоо утгатай боловч дээрх “унт-, нойрс-” гэдгээс “хажуул-” гэдэг нь “хэвтээ орон зай”-гаар унтахыг орлуулсан бол “дугжир-” гэдэг нь авиа дуурайх үгээр буюу унтахын нэг шинжийг заасан үгээр төлөөлүүлжээ.



Энэ гурван ойролцоо үгээс “айлчин, айлчил-” нь өргөн дэлгэр хэрэглэгдэнэ. Учир нь түүний язгуурын утгын агуулга нь багтаамж ихтэй юм. Үүнд:



гэх мэтээр түүний утганцрыг хоршоо ба нийлмэл үгсээр барагцаалж болно.

Ю.Д. Апресян салаа утга ба ойролцоо утгын талаар өгүүлэхдээ “Эцсийн эцэст, салаа утга ойролцоо утга хоёр нь хам цагийн үүднээс ч нарийн холбоотой юм. Олон утгат үг уг ёсоороо хэд хэдэн ойролцоо үгийн үүр эгнээнд ордог. Үүнийг тэмдгээр илэрхийлбэл тохиромжтой юм. Хэрэв “А” гэдэг үг нь а, б, в, г гэсэн салаа утгатай бол А, Б, В, Г гэсэн ойролцоо үгийн эгнээнд “а” орж болно. “б” нь А, Л, М, Н-д, “в” нь А,

О, П, Р-д тус тус орж болно. Тэгвэл Б, В, Л, М, О, П нь мөн л олон утгатай болно” (Ю.Д.Ап.-1957, стр. 85) гэжээ.

Ойролцоо үгс нь гол буюу ерөнхий утгаараа тохирч, гол бус буюу хэсгийн утгаараа ялгардаг учраас ихэнх нь “ойролцоо утгат үгс”, баганх нь “утгын ялгамжит үгс” гэдэг. Тогоо “Ойролцоо утгат үгийг олон эзэмшин хэрэглэж, түүний утгыг нь нарийн ялгамжлах явдал бол үгийг сонгож оновчтой хэрэглэхэд холбогдож байна. Жишээлбэл, “гээх-хаях-орхих” гурван ойролцоо утгат үг утгын нарийн ялгамжаатай юм. Энэ гурван үг “биеэс салгаж явуулах” утгатай боловч “хэрэгцээгүй болсон зүйлийг дахиж авахгүйгээр явуулах”-ыг “хаях”, “дахиж олохоор хэрэгцээтэй зүйлийг орхисон байвал ”гээх” болно. “Үлдээж хоцроосон зүйлд “орхих”-ын утга тохирох юм. Ийм зүйлсэд үгийг буруу хэрэглэвэл хэлний бядуу байдал илрэх нь гарцаагүй” (Тог.-1993, 722-723-р т.) гэж өгүүлсэн нь ойролцоо үгс утганцраараа өөр хоорондоо ялгаатайг тодорхойлжээ. Иймээс ойролцоо үгсийн утгын бүрэлдэхүүн болсон утганцрыг тодорхойлж, тэдгээрийн нийлэх салах учрыг олбол утгын зохицлыг зөв олох болно.

Б. Ринчен авгай энэ тухай “Айл аймаг гэдгийн язгуур нь ай болох тул монголоор бодогч хүн яагаад айл хүн амь нэгтэйгээрээ нэгэн аймаг, нэгэн ай болдог нь сэтгэлд ургаж, айл аймаг гэдэг хоршоо үг, даруй зураачийн дүрсэлсэн зургаас дутуугүй тодоор ашиг сонирхол, амь нэгтэй айл хүнийг айл аймаг гэж хэл нэгтэй, аж төрөн амь зуух байдал нэгтэй, ижил дасал болсон хэсэг бүлэг хүн үзэгдэх мэт санагдах ажээ. “ (Б.Рин.-1967, 2-р т.) гэх мэтээр тайлбарласан нь ойролцоо үг бүтэх сэтгэл зүйн талаас буюу хэлэхүүний өнцгөөс үзсэн хэрэг болно. Ингэж нэг үг нь нөгөө үгийн утгыг бүрэн тайлах нь ойролцоо утгатай хоршоо үгнээ тодорхой илэрдэг ажээ. Т.Пагва “амар жаргал, зовлон зүдгүүр, баяр хөөр, сүр жавхлан, харгуй зам, цэрэг цуух” гэх мэт хоршоо үгийг синоним (Т.Паг.-1959, 99-р т.) гэж үзсэн байдгийг ч дурдаж болох юм. Харин Ж. Төмөрцэрэн ойролцоо үгээр шүлгийн шад бүтээнэ (Ж.Төм.-1964, 1974, 38-39-р т.) гээд,

Ардын цэрэг хил хязгаарт сууж,

Өдөр шөнөгүй манана.

Цусны цэрэг судлын амсар сахиж

Агшин хоромгүй сахина. (Д. Нацагдорж)

гэхэд “хил хязгаар”, “агшин хором” гэсэн ойролцоо хоршоо үгийг хэрэглэсэн бол

“Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар

Үр ач бидний үржсн орон

Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг

Монгол хүн бидний сэтгэлийг сорсон орон (Д. Нацагдорж)

гэхэд “газар-орон-нутаг” гэсэн ойролцоо үгийг салгаж, мөрүүдийг ойролцоо үгээр зангидсан байна. Энэ тухай М. Базаррагчаа “Хоршоо үг нь үндсэндээ ойролцоо ба эсрэг утгад түших тул авианы болоод утгын зохист найруулга цогцлоох эрхэм чухал хэрэглүүр болдог бөгөөд хоршоо үггүйгээр яруу найруулах гэдэг ихэд хомсдох ажээ (М.Баз.-1990, 37-р т.) гэж тэмдэглэн, Б. Ринчений “Сандо амбан” (Уб.,1973), Лувсанданзаны “Алтан товч” (Уб.,1957) зохиолын ойролцоо хоршоо үгийг 1. Жинхэнэ ойролцоо үг (*ааш ааль, ядуу буурай, эгэх буцах, хов жив, хилс гүжир, хууль дүрэм, өвчин эмгэг, өө сүлдэс*), 2. Ойролцоовтор үг (*айлтгал мэдээ, алс бөглүү, алхах гишгэх, ач үр, нэр сүр, нутаг хязгаар, санаа зориг, чадамгай дадамгай, дуган сүм, гайхах биширэх, гудамж зээл*), 3. Зүйрлэсэн ойролцоо үг (*аажим талбиун, адаг сүүл, дуу хоолой, дээр эрт, зах үзүүр, мухар сохор, нарийн чанд, өнгө будаг, сав сааль, санаа оноо, хөл үймээн, хавчих*

хайрах, хир хилэнц, хов хожуу, тохоон томилох), 4. Төрөлжсөн ойролцоо үг (ард амьтан, бичиг баримт, гэдэс дотор, мал сүрэг, мах булчин, хүн ам, явах хөдлөх, цай идээ), 5. Зүйлчилсэн ойролцоо үг (агь ганга, асуудаг хэлдэг, буудах дүүжлэх, дуу шүлэг, соёл боловсрол, харгис муухай, хэнгэрэг бүрээ), 6. Авианы сэлгэцээр үүссэн жинхэнэ ойролцоо үг (аахар шаахар, ажиг сээжиг, айван тайван, ийм тийм, өдий төдий, элий балай, яадаг ийдэг), 7. Язгуур нэгтэй ойролцоо үг (зай завсаргүй, төрөл төрөгсөд, хэм хэмжээ), 8. Авиа ба дүрс дуурайх ойролцоо үг (жингэнэх хангинах, нам гүм, яв цав, халт мөлт), 9. Тогтвортой ойролцоо үг (бичиг хачиг, газар сайгүй, зуд турхан, орь бархи, мөнгө санга, чүү чамай, хир даг, эрүүл эсэн) гэж ангилсан байна. Эдгээрийн эхнийх нь тухайн өгүүлбэрт солиход бие биеэ бүрэн нөхөж чадах тул жинхэнэ ойролцоо үг болж болох юм. Ийнхүү ойролцоо хоршоо үгийн нэг нь нөгөөгөө орлож болох юм.

О.С.Ахманова хосолсон ойролцоо үгс орос хэлнээ дараах хэдэн зүйлээр ялгарч байдгийг тодорхойлсон байна. Үүнд: 1. Өөр язгуур бүтээврээр бүтсэн (аэроплан-самолет; биография-жизнеописание; библиотека-книго хранилище; орфография-правописание); 2. Язгуур нь өөр боловч нэг үг дагавраар бүтсэн (аэробомба-авиа бомба; двугодованный-двухлетний; единогласие-единодушие; накидать-набросать; языковедение-языкознание); 3. Язгуур нь нэг боловч үг дагавар нь өөр (ветроген-ветреник; китаист-китаевед; мирный-миролюбивый; хитроумный-хитрый; хромой-хромоногий) 4. Нэг нь нөгөөгөө орлодог (зав-заведующий, утиль-утильсырьё; унтер-унтер-офицер) 5. Үгийг хэвшмэл хэлцээр орлох (квартилата-квартирная плата, фабком-фабричный комитат; зарплата-заработная плата) (О.С.Ах.-1957, стр. 230-231) Эдгээрийн зарим нь нэг үгийн хураасан хувилбар мэт санагдаж байна. Жишээлбэл, монгол хэлний “ня-бо, НҮБ, МУИС, МОНЦАМЭ” зэрэг нь тухайн хэвшмэл үгийн хувилбар болно. О.С.Ахмановын дээрх таван зүйлээр ялгасан ойролцоо үгсийн зарим нь төсөөт үг (единогласие-единодушие, хитрый-хитроумный) болох аж. Орос хэлэнд “кентавр-центавр; матрас-матрац; систерна-цистерна; фланец-флянец; внутренно-внутренные” (О.С.Ах.-1957, стр. 197) гэсэн авианаас үүдэлтэй хувилбар байдаг боловч монгол хэлнийх шиг (хага хуга, түс тас) гэх мэтээр хоршин хэлдэггүй.

2. Монгол хэлний “Гэр бослоо-Бид гэр босголоо. Гэр баригдлаа-Бид гэр барилаа” гэхэд “бос-, босго-, баригд-, барь-” гэсэн үйл үг нь хэвийн дагавраар ялгаатай боловч мэдэгдэхүүн буюу бодит талаас, утга адил юм. Гэвч эдгээрийг ойролцоо үг гэж болохгүй. Учир нь, эдгээрийн үйлдэгчийн бүтэц өөр юм. “Номд мөнгө зарна.- Номд мөнгө үрнэ.- Номд мөнгө сүйтгэнэ.” гэхэд “зар-, үр-, сүйтгэ” гэсэн үйл үг нь адил бүтэц бүхий өгүүлбэрт ойролцоо утга үүсгэх тул эдгээр үйл үгсийг ойролцоо үг гэнэ.

Би архи хэтэрхий ууж, элэгний өвчин хөдлөв. (Б. Ринчен. Үүрийн туяа, Уб., 1971, 86-р т.) гэхэд, “уух”-ыг “хүртэх, зооглох, балгах”, “хөдлөх”-ийг “үүсэх, илрэх, дахих” зэрэг үгсээр солиход, уул өгүүлбэрийн үйлдэгчийн бүтэц адил байна. Харин “хүрт-, сүйтгэ-” хэмээх үйл үг нь үйлдэгдэх ба үйлдүүлэх хэвд буй боловч бусад ойролцоо үйл үгийн эгнээнд багтан оржээ.

3. Монгол хэлний ойролцоо үг нь их төлөв үйл үг, тэмдэг нэрийн зүйлд элбэг тохиолдох ажээ. (Ж.Төм.-1974, 22-р т.) Ю.Д.Апресян ойролцоо үг нь тохицолт бус буюу үүсмэл бус (а. эцэх-цуцах; б. чилэх-алжаах (Б.Сум., Б.Лув.-1960, 173-р т.); ховдог-сүвдаг-хомхой-албин (унд идээнд маш ховдог); а. тээг-тээр-төвөг, б. ярииг-ярвиг, в. тойв-саад (садаа)-тотгор); тохицолт буюу үүсмэл (а. шунахай-авилгач-авангар (авамхай), б. доломцог-долгомцог, ядрах-зүдрэх; а. аахлах-аяглах, б. загнах-зандрах) гэсэн хоёр янз

байдаг (Ю.Д.Ап.-1974, стр. 223) хэмээн үзэж, орос хэлний “равный-равенство” гэж үүссэн тохицолт ойролцоо үг нь энэчлэн үүссэн бусад үгсээс ойролцоо үгтэй ихэд дөхөж очдогоороо ялгардаг” гэжээ. Цаашилбал, тэрээр, ойролцоо үгсээс өгүүлбэр бүтээх үүсмэл ойролцоо үгийг хасах юм бол зөвхөн нэг үгсийн аймагт хамаарах ойролцоо үгсийг дээр үзсэн шиг ойролцоо үг гэж болох ба үүнийг үүсмэл нөхвөрлөх ёс гэж тайлбарлаж болно гэжээ. Жишээлбэл, орос хэлний “стоит-как только (Стоит ему войти-Как только входит.), сам-лично (Скажите это ему самому- Скажите это лично ему), один-только (Я скажу об этом ему одному-Я скажу об этом только ему)” гэх мэт.

Ийнхүү язгуур, үндсийн утга эс хувирах боловч зөвхөн хэлзүйн утга өөрчлөгдөх нөхвөр (супплетивизм)-ийг А.А.Реформатский ойролцоо үг бус, хэлзүйн арга (А.А.Реф.-1967, стр. 311) гэж үзсэн боловч Ю.Д.Апресян нөхвөрийг үүсмэл боловч ойролцоо үгтэй ихээхэн дөт юм гэжээ. Энэчлэн Т.В.Булыгина, С.А.Крылов нар бүтээврүүдийн хэлбэрийн ижил тал арилах тусам хувилбар бус, ойролцоо бүтээвэр, нөхвөр болно (Т.В.Бул., С.А.Кры.-1990, стр. 311) гэжээ. Нөхвөрлөх ёсыг Б. Ринчен гуай “Европ зүгийн монголч эрдэмтэн эл “намайг, надур, надача” гэх зэргийг “супплетив хэлбэр” гэж нэр зүүн, “би” гэж байтлаа, гэнэт шал өмнөө хэлбэр гарсныг эл нэр томъёогоор таглан аргалж байсан нь...” (Б.Рин.-1973, 37-39-р т.) гэж шүүмжилсэн байдаг.

Дж. Лайонз бичихдээ “Нэг өгүүлбэр (S_1) нь нөгөө өгүүлбэр (S_2)-ээ далд агуулж байдаг. Хэрэв чацуу хоёр өгүүлбэр нь ижил бүтэцтэй бол нэг нь нөгөөгөөс нэг гишүүн (X)-ээр ялгарах ба тэр гишүүн нь нөгөө өгүүлбэрийн гишүүн (Y)-ий байранд орвол, “х.у” гэсэн хоёр гишүүн нь ойролцоо гишүүн (үг) болно. “ (Д.Лай.-1999, 475-р т.) гэж үзжээ. Жишээ нь:

Аавын хүү нэртэй

Ээжийн охин нүүртэй

Авах бүр адтай

Идэх бүр идтэй

гэхэд “нэртэй -нүүртэй, адтай-идтэй” гэсэн гишүүдийн нэг нь нөгөөгийн байрнаа орох боломжтой тул ойролцоо үгс болно. Дж. Лайонз ойролцоо үгийг 1) утга болон сэтгэл хөдлөл, яруу чанараараа бүрэн ба бүрэн бус тохирох; 2) аль ч эхэд сольж болох, зарим эхэд сольж болох гэж үзээд, ойролцоо үгийг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

1. бүрэн ба түгээмэл тохирох (Утга нь бүрэн тохирч, аль ч эхэд солиход утга өчүүхэн гаждаггүй). Зарим эрдэмтэд хэлэнд ав адил үг байх учиргүй гэж байхад зарим нь нэрлэж байгаа юм ба ухагдахуун нь ижил үг цөөвтөр боловч бий (аэроплан-нисэх онгоц, чийчаа-машин, алим-яблока, хиам-колбаса, хэл шинжлэл-хэл судлал, бүтээвэр-морфем, цонх-гэгээвч, нийгэм журам-социализм, эв хамт- коммунизм, гай-барцад, дэг-журам) гэж үзэж байна. Д. Отгонсүрэн “гай барцад, дэг журам” гэсэн үгсийг орлуулж болмоор байвч ихэнхдээ хоршиж хэрэглэгдэх болсноос гадна, “гай” гэдгий нь ямар хүн хэлж болох вэ, “барцад” гэдгий нь хэн хэлж болох вэ гэж эргэцүүлбэл мөн л найруулгын ялгаа гарч байгаа зэргээс монгол хэлэнд дублет (туйлын синоним) байна гэхэд хэцүү болж байна (Д.От.-1975, 86-р т.) гэж үзэж байна. Жич, дублет (хувь үг) нь нэг язгууртай өөр өөр дагавартай, “девчонка-девушка, Танечка-Танюшка, березник-березняк, гегелист-гегельянец” зэрэг үгсийн хувилбарыг хэлдэг байна. (А.А.Реф.-1967, стр. 90) Хувь үг нь авиа, бүтээвэр, үг, өгүүлбэрт нэгэн адил байдаг тухай О.С.Ахманова дурдаад, орос хэлний “дилетантизм-дилетантство, зал-зала, выскользоть-выскользывать, волчиха-волчица, безвкусье-безвкусица, петуший- непетушиный”

(бүтээврийн хувь үг), *волость-власть, сторена-страна* (гарлын хувь үг) (О.С.Ах.-1966, стр. 144, 71) гэх мэт жишээ татжээ.

Гэтэл М.М. Маковский “Хэлний дотоод хүчин нь тэгш хэмт бус байдлыг буй болгох хандлагатай тул хэлэнд туйлын ойролцоо үг байж болохгүй юм” гэсэн бол В. И. Кодухов “хувь үг буюу туйлын ойролцоо үг нь ойролцоо үг болж чадахгүй” гэж үзсэн байна. Б. И. Косовский жинхэнэ ойролцоо үг хангалттай байдаг гэж үзээд орос хэлний

1. нэмсэн яруу утгагүй өөр язгууртай үгс (*кидать-бросать, выворачивать-выкручивать*) cf. *гэмтэх-бэртэх, гэмшил-харамсал*
2. харь ба унаган үгс (*автономия-самоуправление, аналогия-сходство*) cf. атлас-газрын зураг, банан-гадил, манерк-бяцхан дашмал, команд-баг
3. нэг язгууртай үгс (*бросать-обрасывать (бомбы), менять-разменивать (деньги)*) cf. харамсал-харуусал
4. хэлц ба хэлц бус үгс (*бездельничать-быть баклуши, побеждать-братъ верх*) cf. *гэнэн-зулай нь битүүрээгүй, элдүүр нь гүйцээгүй - сая унасан нойтон ишиг*
5. яруу утга бүхий үгс (*валандаться-канителиться, барахло-монетки*) (*оронцоглох-новиорох, хог нови-чавганц (чувганц)*) cf. *хурдлах-гялалзах*
6. утга салаалах (*мчаться-нестись-лететь, входить-влезать (в чемодан)*) cf. *нисэх-давхих; хүний мөсгүй; урагштай-өөдлөх, нударгатай болох*
7. хэлцийн доторх үгс (*Ветер*) *стихулегся. (Вино) ударяет\бросается в голову* (Б.И.Кос.-1974, стр. 81-82) cf. *гэрээсээ\удамжинд хөөн гаргах, толгой түрүүгүйнүүр нүдгүй занчих, шары нь\ямаан омгий нь хөдөлгөх*

гэх зэрэг ойролцоо үгийг жишээлээд, өгүүлбэр дэх үгсийн утгын зохицол ба утгын тохирлоороо бүрэн таарсан жинхэнэ ойролцоо үг гэж үзсэн байна. Ийнхүү ойролцоо үгийн нэг нь нөгөөгөө утгын хувьд бүрэн орлох дээрх жишээг Ю.Д.Апресяны өгүүллээс авсан байна. (Ю.Д.Ап.-1969, стр. 79-80) Ю.С.Степанов бодит ба хийсвэр ойролцоо үгийн ялгааны тухай “Хийсвэр ойролцоо үгс нь нэг ухагдахууны ялгарааг илтгэхийн үүднээс, уул хэлний тухайн цаг үед адил болж буйг хэлдэг бол бодит ойролцоо үгс нь нэг юмыг шинэ хуучнаар нь нэрлэж өөр болж буйг хэлдэг юм.” (Ю.С.Сте.-1975, стр. 32) гээд, бодит ойролцоо үгс нь хэлний түүхэн үзэгдлийг үргэлж агуулж байдаг” гэсэн нь дээрх хувь үг, ялангуяа гарлын хувь үгтэй холбоотой байгааг анзаарна уу.

Иймээс монгол хэлнээ нэг гаралтай боловч тэр нь мэдэгдэхээ байсан

1) өөр-өмнөө, солих-сэлэх-халах, тагнуул-тэншүүл, тахих-тайх, алах-талах, танах-тонох, төлөв-төрх, уйлах-хайлах, яриг-ярвиг-уриг, урвах-хөрвөх, урьтах-өрсөх, ухаан-сэхээ, ухаарах-сэхээрэх, халаа-сэлээ-солио, хил-хязгаар-зах-зааг, санаа-сэтгэл, ховдог-хомхой, алс-хол (холхи), цээр-цааз, цээрлэх-цаазлах, холбоо-сүлбээ, бачимдах-бухимдах, дэлгэр-цэлгэр, шаардах-шавдах, шингэх-суух, шүтэх-түших, эе-эв, энэлэх-шаналах, эцэх-цуцах, ядах-зүдэх, ядрах-зүдрэх, яаран-дайран, одох-эчих, ялах-дийлэх, ааш-ааль-авир, загнах-зандрах, адаг-эцэс, ядар-хэдэр-адайр, гамнах-хэмнэх, ая-эв, тав-таалал, бяцхан-бичил, үргэлж-үүрд, овоорох-шаваарах, буцах-няцах, гүтгэх-гүжирдэх, мөрдөх-мөшигх, дур-зориг, дуусах-төгсөх-дүүрэх, жир-ер, жирийн-ерийн, журам-ёс, завсар-зуур, зодох-нүдэх, гажууд-гажуу, таарах-тохирох, ноос-унгас, халуурах-бүлээрэх, цээр-цэвэр, нягт-нямбай, завхай-зайдан, хань-хамсаа, хямд-хялбар, шаардуу-шамдуу, шавар-шавхай, найр-наадам, сүг-сүнс, гуйх-гувилах, дайрах-давирах, хавчих-хайрах, шахах-шаардах, дэгжих-дэвших, гоёх-гоодох, ядуу-зүдүү, хашир-башир, энх-мөнх

Хэдийгээр А.П.Евгеньева зэрэг эрдэмтэд ойролцоо үгийг “яруу тодорхой шинж, сэтгэл хөдлөлийн байдал, найруулгын өнгө аясаараа, илтгэж буй утгыг ялгаж буй төрхөөрөө янз янз байх ба олон хэлбэр бүхий утга нь адил, харьцангуй ойролцоо утгатай үгс юм. Мөн гарал хийгээд хэлбэрээрээ янз бүр байдаг үгс” (А.П.Ев.-1970, стр. 8) гэж үзсэн боловч монгол хэлний эдгээр үгс (1) нь авиалбар ба үелбэр хэд хэдээр сэлгэж, бас нэмж хассанаар үүссэн үгс болно.

2) Нэг гаралтай нь мэдэгдэхүйц *аажим-уужим, адил-ижил, урвах-хөрвөх, хаширах-бархирах, ангах-цангах, замрах-завхрах, баагих-уугих, дайтах-дайлах, бардах-эрдэх, ахар-охор, бөх-бэх, шалих-ялих, гатлах-гэтлэх, гэх-хэмээх, ахих-дахих, зав-зай-завсар, ид-шид, идтэн-шидтэн, уухилах-аахилах, эрэмдэг-зэрэмдэг-заримдаг, энэ-эл, умбах-шумбах, андуу-эндүү, халт-хулт, үнэр-танар, хага-хуга, олиу-солиу, бүрий-барай, харуй-бүрүй, ээж-ижий, хэн-ян, юутай-хүүтэй, ааш-бааш, арвагар-сарвагар, ундуй-сундуй, аахар-шаахар, ойчин-цойчин, үймэн-айман, элдэв-шалдав, халтар-хултар, арай-чарай*” зэрэг үгсийн эхнийхийг бодит ойролцоо үг, сүүлчийнхийг ойролцоо утга бүхий төсөөт үг (Б.Ид.-2005, 11-р т.) гэж ялгаж болно. Иймээс “дэг журам” гэх мэт харь үг бүхий ойролцоо утгат үгсийг туйлын ойролцоо үг гэхээс гадна “*ангах-цангах, ялих-шалих, аахилах-уухилах, халт-халт*” гэхчлэн хоршсон ч, эс хоршсон ч ямар ч эхэд аль нь ч орлож болох үгсийг туйлын ойролцоо үг гэж болмоор боловч 1-рт, эдгээр үгс нь авиалбарын чөлөөт сэлгэцээр бий болсон хувилбар болох ба яваандаа утга ялгаж болох, эсвэл, зарим нь мартагдан “үнэр танар” гэдгийн “танар” гэдэг шиг дагалдах үүрэг бүхий чимэг үг ч болж болдог. 2-рт, эдгээр үгсийн (2) ганц хоёр авианы сэлгэц нь ойролцоо үгийн авианы бүрэлдэхүүн шиг эрс өөр болгож чадахгүй юм.

Гэвч Ш.Балли “Үгийн гарваль судлал нь ойролцоо үгсийг судлахад ямар ч бодит үнэ цэнгүй зүйл юм” (Ш.Бал.-1961, стр. 174) гээд, ойролцоо үгсийн ялгааг гарлын утгаар тайлбарлах гэсэн эрмэлзэл итгэлгүйгээр барахгүй хортой юм” гэж үзсэнийг энэ тухайд дурдъя.

Т.А.Бертагаев зэрэгцэх утгатай тэг холбоосоор холбогдсон хоршоо үг (биномы) нь ойролцоо утга бүтээх идэвхтэй сан болох ба утгын ялгаагүй ойролцоо үг бүтээдэг. (Т.А.Берт.-1971, стр. 60-61) гээд, 1) бие даасан (*бэлэг тэмдэг*), 2) дагаврын хувилбар (*дотоод-дотуур*), 3) харь үг хоршсон (*жүжиг-драм*) ойролцоо үгс байдаг гэжээ. Үүнд Д. Отгонсүрэнгийн үзсэнчлэн найруулгын ялимгүй ялгаа байж болох юм.

Тэгэвч хэлний тогтолцоо нь зарим нэг сэтгэлэг байдалд тэмүүлсэн “нэг хэлбэр-нэг утга” гэсэн зарчмаар тайлбарлах юм бол хэлбэр утгын зөрчил арилах болно. Үнэндээ бүрэн ижил утга нь янз бүрийн хэлбэрээр илрэх туйлын ойролцоо утга нэн ховор юм. Хэрэв тухайн хэлний ормол үгийн ачаар нэг утга илтгэх ойролцоо үгс нь хоорондоо өрсөлдөж эхэлбэл хэдийгээр анхныхаасаа ялимгүй ялгаатай боловч тэдгээрийн нэг нь учир утгатай болох ба туйлын ойролцоо үгс нь утгаараа ижил биш, харин ойр, хуурмаг ойролцоо үгсэд найр тавьж өгдөг” (И.М.Коб.-2000, стр. 40) гэж И.М. Кобозева туйлын ба хуурмаг ойролцоо үгийн талаар тайлбарлажээ.

Ш.Лувсанвандан “Ямар ч нөхцөл байдалд солин хэрэглэж болох тийм шинж чанартай утга ойролцоо үгс маш цөөхөн тохиолдох боловч энэ мэтийн утга ойролцоо үгс бидний хэлэнд хэлний үгсийн санд зохих хэмжээтэй байдгийг үгүйсгэж болохгүй.” (Ш.Лув.-1962, 503-р т.) гээд, “Ийм үгс нь нэгэн адил утга ухагдахууныг илтгэх бөгөөд үг найруулгын хувьд ч, хэрэглэх байдлаараа ч төлөв ялгамжаагүй тул утга өнгийн хувьд бүрэн төгс тохирох аж. Жишээ нь:” *үгсийн бүрэлдэхүүн-үгсийн сан, хаяг-адрес, мөхөх-*

сөнөх” гэх мэт. Гэвч “сөнөсөн галт уул” гэхээс “мөхсөн галт уул” гэхгүй, харин “мөхсөн язгуур” гэхээс “сөнөсөн язгуур” гэхгүй” гэж тэмдэглэжээ.

Өвөр монголын Тогоо “бүрэн ижил үг ховор тохиолдоно” хэмээгээд “сурагч-шавь, эх-ээж, охин-хүүхэн, шорон-хар гэр” (Тог.-1993, 726-р т.) зэрэг жишээ татсан байна. Энхбат “ижил утгатай үг”-ийг адил утгатай ба ойролцоо утгатай гэж хоёр ангилаад, яг адил утгатай үгсэд “зөн-тоосго, гийчин-зочин, Хатан гол-Хуан Хэ мөрөн” зэрэг үгсийг багтааж, хэрэг бодисыг заан, ухагдахууныг илтгэх, найруулгын нэг өнгөтэй байдаг зэргээрээ адил утгатай үг болно. (Энх.-2005, 741-р т.) гэжээ. Тэрээр утга буюу найруулгын өнгийн талаар бага сага ялгаатай “ялгаа-зөрөө, арвилах-гамнах, ярииг-төвөг” зэрэг үгсийг ойролцоо утгатай үг гэж үзжээ. Үүний эхнийх нь мэдэгдэхүүний талаас үзэж, нэг юмыг өөр өөрөөр нэрлэж, аажмаар ойролцоо үг болно. Сүүлчийнх нь хэлэгдэхүүний талаас, нэг ухагдахууныг өөр өөр нэрлэж, тэдгээр нь утгаараа ижилсэх хандлагатай байдаг ажээ.

2. бүрэн ба түгээмэл бус тохирох (Утгаар бүрэн тохировч, тухай тухайн эхэд сольж болдоггүй). Жишээ нь:

“Эрүүл энх байвал өдөр бүр чийрэг” (Д.Н) гэхэд “чийрэг” гэдгийг “чанга, хатуу, идэр, тэнхлүүн, хүчирхэг, чадалтай” гэх мэт үгсийн аль нэгээр солиход утга гаждаггүй юм аа гэхэд найруулга хомстох ажээ. Тэр ч байтугай “чаараг” гэсэн хувилбар үгээр соливол бичгийн бус, ярианы хэлний буюу нутгийн аялгууны шинжтэй болж, зохисгүйднэ.

3. бүрэн бус ба түгээмэл тохирох (Утгын багтаамж өөр боловч аль ч эхэд сольж болно). Жишээ нь:

Агуу сайхан нар минь агаар тэнгэрт мандана. (Д.Н)

Идэр сайхан биеийг өвчин эмгэг гутаана. (Д.Н) гэхэд “агаар тэнгэр, өвчин эмгэг” гэх хоршсон ойролцоо үгийн нэг нь нөгөөгөө орлож болно. Гэвч “агаар” гэвэл “хүн, амьтан, ургамлын амьдралд зайлшгүй хэрэгтэй хийн биет”, “тэнгэр” гэвэл “газрын дээд хэсэгт байх бидний нүднээ үзэгдэх агаар мандал”; “өвчин” гэвэл “бие махбодын хэвийн үйл ажиллагаа алдагдаж хямрах эрүүл биш байдал”, “эмгэг” гэвэл “хүн амьтны биед тогтсон гэм согог” гэсэн утга илтгэж байгаа тул эдгээр хос үгс нь ялгаатай юм. Иймээс “Ойролцоо үгийг тодорхойлохдоо ихэвчлэн түүний ерөнхий утгад түших биш, харин тэдгээрийн ялгаанд тулгуурладаг. Утгаараа бүрэн таарч буй үгсэд хувь үг, үгийн хувилбар зэргийг тооцдог боловч байнга утгаараа ялгарч буй үгсийг жинхэнэ ойролцоо үг хэмээн үздэг болж байна” (Ю.Д.Ап.-1974, стр. 217) гэж А.Б.Шапирогийн санааг чухалд үзсэн байна. Гэтэл “агаар тэнгэр”-ийг “огторгуй” (Нар, сар, од эрхэс болон дэлхийг хүрээлсэн агаар мандал, сансрын орон зай, тэнгэр) хэмээх үгээр орлуулж болно. Гэвч “огторгуй” хэмээгч нь “огторгуйн орон зай, огторгуйн төв, огторгуйн оёдол, огторгуйн бүс, огторгуйн хүнхэр” гэх мэтээр шинжлэх ухааны найруулгын үг болох тул дээрх өгүүлбэрт утгаараа бүрэн бус ба хэрэглээгээрээ түгээмэл бус тохирох ажээ.

4. бүрэн бус ба түгээмэл бус тохирох (Үгийн утга, хэрэглээгээр үл тохирох ойролцоо үг). Жишээ нь: Хаврын наран шарлаад, өвөлжөөний дотор бүлээн дулаан (Д.Н) гэхэд үг бүтэх аргаар үүссэн “шарлах-шаргалтах” гэсэн ойролцоо үг нь уг эхэд сольж болохгүй бөгөөд утга нь ч үл тохирно. Харин “намрын өвс шарлах, үүрийн гэгээ шарлах” гэхийг “шаргалтах” гэж сольж болно. Харин “шарлах” гэдгийн салаа утга болох “шар өвчин тусах”, мөн “шартах” (шар хөөрөх), шарлаах (зовоох) гэсэн үгсээр сольж бүр ч болохгүй юм.

Ойролцоо нэгж нь утга ойр байхын зэрэгцээ бие биеэсээ ялгарч, төвөгтэй болгодог учраас зарим эрдэмтэд ойролцоо нэгжийг судлахаас няцдаг боловч Ю. Д. Апресян түүнийг нарийвчлан судалж, “Ойролцоо нэгж хэлэнд бодитой оршин буй хам цагийн утгын ай юм. Утгаараа ялгарахын хамт бүрэн ижилсэж байгаа зөвхөн толь зохиоход гардаг тийм нэгжийг ойролцоо нэгж гэж болно. Ойролцоо нэгж нь үг судлал хийгээд өгүүлбэрийн нэг орчин ба бүтцэд хэрэглэгдэж буй, эхийн чанд нөхцөлд бие биеэ орлох чадвартай юм. Ийм харьцаанаас хэлний түүхэн явцад бий болж, нэг тогтолцоонд хамаарах бүх үг хэллэг нь ойролцоо нэгжийн үүр эгнээг бүтээдэг” (Ю.Д.Ап.-1957, стр. 88) гэж үзсэн нь Дж. Лайонзын дээрх ангилалтай нарийн холбоотой юм.

Ийнхүү Дж. Лайонз ойролцоо утгын зэрэглэлийг тогтоосон бол Ю.Д.Апресян 1)ойролцоо утга бүрэн тохирох, 2)ойролцоо утгын нэг нь нөгөөгөө багтааж тохирох (“*достигать*”=“*хэмжээ*” (онончтой буюу онончтой бус), “*доходить до*”=“*тодорхой хэмжээ*” гэхэд эхнийх нь “бүхэл, ерөнхий” гэсэн утгатай бол сүүлчийн үг нь “хэсэг, тодорхой” гэсэн утгатай юм.) 3)ойролцоо утгын нэг нь нөгөөгөө нөхөж тохирох (орос хэлний “*приниматься*”=“*үйл ажиллагаа*”, “*браться*”=“*үйл ажил*” гэсэн хоёр үгийн эхнийх нь хийсвэр, сүүлчийнх нь бодитой боловч “*приниматься/браться*” (орох, оролдох, хүлээн авах/хийж эхлэх) гэдэг ойролцоо үг нь “*браться/приниматься за работу/за учение/за чтение/за дело/за картину/за книгу/за письмо*” гэж бие биеэ солбицож болно, 4)ойролцоо үг нь утгаараа бүрэн тохирохгүй нь хуурмаг ойролцоо үг (квазисинонимия) болдог. Энэ нь төрөл зүйлийн утга бие биеэ нөхөн солбицдог. Жишээ нь, орос хэлний *объединение* (нэгдэл)-*союз* (холбоо), *остричь* (бүрмөсөн авах)-*постричь* (хэсгийг нь авах) гэж ангилаад (Ю.Д.Ап.-1974, стр. 230-239), эдгээр дөрөв нь дотроо утгын ба үгийн, бүтээвэр-өгүүлбэрийн ойролцоо үгс гэж задран, $3 \times 4 = 12$ гэсэн ойролцоо үг бүтэх ажээ. Ингэж ойролцоо утгын зэрэглэлийг Дж.Лайонз, Ю.Д.Апресян нар ялгасан бөгөөд Л.А.Новиков “Тухайн эхэд ойролцоо үгийн нэгийг нөгөөгөөр солих боломж их байх тутам, уг үгсийн утга хэдий чинээ адил байх тутам утга ойр байх зэрэглэл буюу чанар нь их байх болно.” (Л.А.Нов.-1982, стр. 227) гээд, ойролцоо үгийн гол шинж нь нэгийг нь нөгөөгөөр солих, утгыг тодчилохдоо янз бүрийн үнэлэмж оруулах явдал юм гэж үзсэн байна. Жишээ нь:

1. Умард уулын оройгоор бараан манан оргин буцалж (умард-хойд;уул-нуруу; хянга-хяр-орой-оргил-дээгүүр-толгой-таг; бараан-бүгээн; манан-будан-хүдэн-униар-уур-утаа;оргих-дэврэх-хөөрөх-бургих-ундрах;буцлах-оргилох-даргилах)

2. шамарга цас бөөн бөөнөөр хаял-аад (шамарга-шуурга-салхи; цас (хяруу, мөс); бөөн бөөн-баан баан; хаялах-шидэх-чулуудах-цацах-дүүгүүрдэх)

3. эргэн тойрон харанхуйл-ж (эргэн тойрон-орчин тойрон; харанхуйлах-харанхуй болох; бүрэнхийлэх-бүрэнхий болох)

4. дөрвөн зүгийг олохуйяа (зүг-чиг; олох-онох (хүртэх, завишх))

5.бэрх. (Д.Нацагдорж) (“бэрх-хэцүү-хүнд-хүчир-төвөгтэй-амаргүй-сүрхий)

гэхэд “умард-хойд; эргэн тойрон-орчин тойрон; бэрх-хэцүү” зэрэг ойролцоо үг нь нэг нь нөгөөгөө нөхөж болно. Энэ нь Ю.Д.Апресяны дээрх ангиллын 3-рхад хамаарна. Харин “оройгоор” гэхийг “хяраар” гэж сольж болох авч “орой” нь ерөнхий, “хяр” гэдэг нь тодорхой (дээд ирмэг) утгатай тул Ю.Д.Апресяны ангиллын 2-рхад багтана. Учир нь, “уулын орой” нь “уулын хяр”-аа өөртөө багтаасан агуулгатай юм.

Л.А.Новиков өөр нэг өгүүлэлдээ “Үүргийн талаас, аль ч болоод тухайн эхийн доторх өгүүлбэрийн агуулгыг өөрчлөлгүйгээр утгын ижил буюу адил шинжээр нь

нэгийг нөгөө үгээр солих боломж чадамж ойролцоо нэгжид байдаг. Ойролцоо үгийг утгаар нь харилцан тэнцүүлэн сольж болдог. (*Тэр хэл судлаач.-Тэр хэл шинжээч. Энэ өндөр залуу байлаа-Энэ өсгөлүүн залуу байлаа.*) Ойролцоо утгыг ялгаж байсан утганцрууд нь заавал ч үгүй саармагшиж, тэдгээрийн ерөнхий утга давамгайлах тутам утгын ойролцоолог тал ихэснэ.” (Л.А.Нов.-1990, стр. 446) хэмээн үзсэн байна. Тэрээр, ойролцоо үгийн гол үүрэг бол солих ба нарийвчлах ёс юм гэжээ. Энэ хоёр нь ойролцоо үгийн хэлэхүүний тал болно. Учир нь, тухайн өгүүлбэрийн санааг шинэ сэргэг утгаар баяжуулахын үүднээс наад зах нь ойролцоо үгсийн үүрээс аль боломжтойг шилж сонгодог. (М.Баз.-2003, 44-р т.) Жишээ нь: *Радио бол хүний тархинд ертөнцийг байгуулах уянга.* (О.Бараанасан) гэхэд “хөг, хөгжим, дуу, яруу сайхан, эгишг, эгишглэн, ая, аялгуу” гэх мэт хэлэхүүний үүр үгсээс сонгож болно. Энэчлэн тархийг “толгой, тэргүүн, сэтгэл, оюун, бодол, ухаан, зүрх, ой той” гэх мэт үгсээр сольж болно. Харин “гавал, уураг” гэх мэт үгийг сонгож үл болно. Ингэж хэлэхүүний ойролцоо үгийн үүрээс үг сонгох нь юм үзэгдлийн шинж чанар, тоо хэмжээ, хэлбэр дүрс, өнгө зүс, үйл байдал, орон цагийг хир зэрэг тодруулан чухалчлахад оршино. Жишээ нь: “...ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурагтай...” гэхийг “ярагтай” гэж солих нь хэвлэлд үзэгдэвч, “зурагтай” нь морины шинжидээ тохирсон үг ажээ.


Монгол хэлний ойролцоо үг үүсэх эх сурвалжийг нэг талаас, бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаа (денотативное отношение)-нд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаа (сигнификативное отношение)-нд үндэслэдэг ажээ.

Энэхүү юмжуулах буюу юмын утга нь хэлний бус үйл ба хэрэг явдлын тухай үнэн мэдээлэл агуулах ба энэ нь дотроо ертөнцийн юм үйл ба хэрэг явдлаас өгүүлэгч этгээд хэл яриандаа хэрэглэхийг онцолсон-утга (актуальный денотат (референт), ертөнцийн олон юм, үйл ба хэрэг явдлыг өгүүлэгч этгээд хэл яриандаа хэрэглэх боломжтой утга (виртуальный денотат (денотат) гэсэн хоёр янз. Үүний эхнийх нь мэдэхүүн, сүүлчийнх нь мэдэгдэхүүний талтай холбогдоно. Тэгвэл дохиожуулах буюу ухагдахууны утга нь ертөнцийн юмсын тухай мэдээлэл хүний ухамсарт хэрхэн илэрч буйг илтгэнэ. Дохиожуулах утга нь юмсын тухай гэнэн ойлголт (ухагдахуун)-д таарч байх ба ухагдахууны хоорондох харьцааг гаргахад оршино. И.М.Кобозева орос хэлний “*Мама спит*” (Ээж унтана) гэхэд “мама” нь “хүн, эмэгтэй, төрүүлэгч” гэсэн утганцартай бол “*спит*” нь “амьтны бодит шинж, амрах нэг хэлбэр, бүхнийг умартах бололцоотой болох” гэсэн утганцраас бүтнэ. (И.М.Коб.-2000, стр. 59-60) гэж тайлбарлаад “Юмжуулах харьцааны онцолсон утга нь янз бүрийн дохиожуулах утга бүхий зүйлсээр илрэх үед юмжуулах ба дохиожуулах утгын ялгаа тодорхой илэрдэг” гэжээ. Жишээ нь: “мама” гэдэг нь “Ирина Сергеевна Смирнова, миний нөхрийн эхнэр, давхрын хөрш, Соёлын сайд, цонхны хажууд зогсож байгаа хатагтай” гэх мэтээр илэрч болно. Монгол хэлнээ өвөр түрий ухдаг хулгайчийг “*хормойчин, халаас ухаачин, суйлаач, улаандаа тулсан хулгайч*” гэх мэтээр хэлнэ.

Адил буюу ойролцоо утгатай үгийг синоним гэж үздэг тул энэхүү ойролцоо үг нь нэг бол, янз бүрийн юмыг нэг ухагдахуунаар нэрлэдэг (хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс), эсвэл нэг юмыг янз бүрээр нэрлэдэг (бодит буюу юмжуулах харьцааны үүднээс) гэсэн хэрэг болно. Ийм ялгаатай байгаа эсэх нь ойролцоо үгийн хэв шинжийн ангиллын анхны баримжаа болно. Үүнийг дараах байдлаар загварчилж болох юм.

Юмжуулах буюу бодит харьцаа

Дохиожуулах буюу хийсвэр харьцаа



“Нэг юмын янз бүрийн талыг ялган онцолж буй үгс, эсвэл янз бүрийн ялгаатай нэг утга бүхий үгсийг ихэвчлэн ойролцоо үг гэнэ” (Б.И.Кос.-1974, стр. 39) гэж Ю. Д. Апресян тодорхойлсны доторх “нэг юмын янз бүрийн тал”, “нэг утгын олон ялгаа” гэсэн томъёоллыг Б. И. Косовский тодорхой бус, мөн ойролцоо үгийн ялгаатай тал (Ю. Д. Апресян)-ыг орхигдуулдаг хэмээн үзсэн байна. Б. И. Косовский “Утгын бүтцийн үүднээс, ойролцоо үглэврийг тодорхойлбол ихээхэн тохиромжтой юм. Ялгах үүрэг гүйцэтгэдэггүй нэмэлт утганцрууд тохиолдол болгондоо бий болж байдаг утгын бүх шинж чанарыг агуулсан үгсийг ойролцоо үгс гэж болно. Өөрөөр хэлбэл, нэмэлт утганцрууд нь тэдгээрийн адил шинжийг илтгэж аль ч тохиолдолд юмыг тэмдэглэсэн утга нь адилхан хэвээрээ хадгалагдсаар байдаг” (Б.И.Кос.-1974, стр. 79) гэжээ. Тэрээр орос хэлний *“направленность, направление, линия, курс, установка, ориентация, уклон, крен, тенденция, устремленность”* гэсэн ойролцоо үгсэд бүгдэд нь “тодорхой нэг зорилгод чиглэх, зорилгод хүрэх” гэсэн утга голлох ба нэмэлт утганцрууд энэхүү ерөнхий утгын хялбархан гаргачхаж боломгүй ялгарааг тэрхэн үед л бий болгодог” гэж үзсэн байна. Энэ нь монгол хэлний *“ханд-, чиглэ-, зорь-, зүглэ-, хүр-, оч-, шийд-, шулууд-, шуудар-, тогт-, тогтоо-, төвшир-, хэвш-, зүгшир-, зурш-, шийдвэрлэ-, занш-, журамш-, хэвшинэ, хэвшир-”* гэхэд “хөдлөх үйл эхлэх, үргэлжлэх, дуусах” гэсэн гол утга болж, тухай тухайн утганцар нь эдгээрийг адил болгох ажээ.

Л.А.Новиков ойролцоо үгийн талаарх эрдэмтдийн саналыг 1-рт, агуулгын үүднээс утгаараа ойролцоо боловч ялгаатай үгс, 2-рт, тухайн эхийн дотор санааг өөрчлөлгүйгээр бие биеэ орлож чадахуйц үгс, 3-рт, янз бүрийн найруулгын шинж бүхий утгаараа адил үгс, 4-рт, тодорхой нэг эхийн дотор нэг юмтай холбоо бүхий утга ойр үгс (Л.А.Нов.-1982, стр. 222-223) гэж ялгасныг нягталбал, 4-рх нь нэг юмыг янз бүрээр буюу шинэ хуучнаар нэрлэлтээр ялгарч буй бодит ойролцоо үгс нь мэдэхүүний талд; 2-рх нь нэг ухагдахууны янз бүрийн шинжийг илрүүлэхийн тулд ялгарсан ойролцоо үгс нь хэлэгдэхүүний талд; 3-рх нь, найруулгын төрөл зүйлсийг ялгахын үүднээс бий болсон ойролцоо үгс нь хэлэхүүний талд; 1-рх нь нэг юмыг яг адилхнаар нэрлэсэн үгс байж болохгүй тул утгаараа ялгаатай ойролцоо үгс мэдэгдэхүүний талд тус тус хамаатай үзжээ гэж барагцаалж болно. Л. А. Новиков ойролцоо үгийг хэлний гадаад дотоод тал, хөдлөнги зогсонги тал гэсэн дөрвөн талаас ялгасан (Л.А.Нов.-1982, стр. 93-108)-ыг

²² Дээрх хоёр дүрсийн тэгш өнцөгт дүрсээр “юм”-ыг, адил хажуут гурвалжны дүрсээр “ухагдахуун”-ыг тэмдэглэв.

Мэдэгдэхүүн

(сигматическое значение)
Тухайн нөхцөлд буй нэг юмс үзэгдлийг өөр өөрөөр нэрлэх нь

1

Хэлэгдэхүүн

(сигнификативное значение) Хэлний тэмдгээр нэг ухагдахууны олон ялгааг илтгэх нь

2

Ойролцоо үг

Мэдэхүүн

(эмотивное значение)
Хэрэглээний цуваанд үгс нь үнэлэмж ба баймжтай болох нь

4

Хэлэхүүн

(синтагматическое (структурное) значение)
Хэлэхийн цуваанд үгс утгаараа зохицох нь

3

гэж загварчилж болно. Үүнийг тэрээр, “үгийн утга” хэмээн нэрлэсэн (Л.А.Нов.-1982, стр. 108) ба ойролцоо үгийг дээрх байдлаар тодорхойлж болно. Л.А.Новиков ойролцоо үгийг тухайн эхэд найруулга тодчилох, солих үүрэг бүхий янз бүрийн хэлбэрээр илрэх ойролцоо буюу адил утгын харьцааг илтгэдэг үг судлалын нэг ай юм (Л.А.Нов.-1982, стр. 227) хэмээн тодорхойлжээ.

И.М.Кобозева “Ойролцоо утгаар тохицсон үгсийг ойролцоо үг” гэж ойролцоо үгийг тодорхойлоод, бүрэн тохирох ойролцоо үг нь утгын ялгаа гарахгүй бөгөөд мэдэгдэхүүн ба мэдэхүүний хувьд ч, хэлэгдэхүүн ба хэлэхүүний хувьд ч ялгарахгүй (*бросать-кидать* (хаях-шидэх), *глядеть* (харах-үзэх), *езде* (газар сайгүй) –*всюду* (хааяагүй), *плебицит* (ардын санал хураах)-*референдум* (нийтийн санал хураах), *заснуть* (унтах)-*уснуть* (унтчих) зэрэг үгс байна (И.М.Коб.-2000, стр.100-р т.) гэжээ. Тэрээр, хэрэв ойролцоо үгс нь найруулга буюу үнэлэмжээрээ ялгарвал түүнийг мэдэхүүний ойролцоо үг (*убегать-драпать-улепетивать*) болох ба орос хэлний “*красивый-красота, доверять-доверие*” гэхэд бодит ба хийсвэр (утга ба хэлбэр), хэрэглээ (мэдэхүүний тал)-ний хувьд таарах авч, үгийн сан-хэлзүйн талаар ялгарч, хэлэхүүний (өгүүлбэрийн) ойролцоо үг болно (И.М.Коб.-2000, стр. 100) гэж үзсэн байна.

Г.О.Винокур нь С. Ульманы адилаар ойролцоо нэгжийг үгүйсгэж, “Хэрэв хэлний хэрэглүүр болох ойролцоо утга гэгч нь хэл шинжлэлийн хийсвэр зүйлтэй биш, харин түүхэндээ бодитой оршиж байсан өнөөгийн тэр амьд хэлтэй холбоотой гэх юм бол ердөө л хуурмаг зүйл” (Г.О.Вин.-1929, стр. 82-92) гэсэн бол Ю. Д. Апресян, С. Г. Бережан нар “Утгаараа бүрэн тохирох үгсийг ойролцоо үг, уг үгсийн утгын бүрдэл болох утганцруудаар өөр хоорондоо тохирох үгсийг ойролцоо үг” (Ю.Д.Ап.-1974, стр. 218; С.Г.Бер.-1973, стр. 372) гэж үзжээ. Б. В. Томашевский нэг юм, эсвэл нэг утга илтгэх үгсийг ойролцоо үг (Б.В.Том.-1959, стр. 536) гэсэн бол А. И. Ефимов “Ойролцоо нэгж нь хэлэхийн бүтээлч үйлийн хязгааргүй бололцоо олгодог зүйл юм. Зохиолч болгон үгийн эрэлд хатахдаа давын өмнө хэлний ойролцоо утгатай “нөхөрлөж” эхэлдэг. “Путь-дорога” гэсэн ойролцоо хослол нь эрт цагийн түүхтэй юм... Ойролцоо нэгж нь найруулгын амин сүнс” гэх мэтээр үзэж (А.И.Ефи.-1969, 84-99-р т.), М. Горькийн “Ойролцоо утгаар ядуу бол ихэд цалгар назгайг төдийгүй бүдүүлэг байгаагийн гэрч юм” гэж хэлсэн үгийг иш татсан байдгийг дурдаж болох юм.

Б.А.Плотников “Ойролцоо нэгж нь хэлэгдэхүүний үзэгдэл, ойролцоо болох (синонимизация) нь хэлэхүүний үзэгдэл юм” гээд, “Үгсийн утга нь бүрэн тохирвол битүү ойр утга, мэдэгдэхүйц ялгаатай байвал задгай ойр утгатай гэж ялгаж болно”

(Б.А.Пло.-1983, 198-р т.) гэжээ. Тэрээр, “Ингэж ойролцоо нэгж нь бодит шинжийг агуулж үгийн утга бүрэн адил болохоос үүсвэртэй хэлний нэрлэх (нэрлэвэр-номема) үзэгдэл бөгөөд тэр нь утгын адил болсон янз бүрийн зэрэглэлээсээ шалтгаалж үгийн утга ялгарах, мөн тийм зэрэглэл бий болж ойролцоо нэгж байна, үгүй гэсэн маргаан үүсгэдэг байна.” (Б.А.Пло.-1983, 195-р т.) хэмээн үзсэн байна.

Энэчлэн Да. Баатар “агуулах” хэмээх үгнээ “авсал-, авдарла-, аягал-, арагла-, үмх-, олгойл-, уутал-, үхэглэ-, нанчил-, намаал-, нэр-, нүхэл-, багварла-, багтаа-, бойрло-, богцол-, борвил-, борд- (мах цусыг гэдсэнд агуул-), бүрцэглэ-, пансал-, хайрцагла-, хавтагал-, хуурцагла-, хармаал-, хүүдийл-, хэмнэ-(хундаганд архи агуул-) хий-, үй-, ховдогло-, хоргол-, хуйл-(хутга), хундагал-, хөнөглө-, хөвхөл-, гэрлэ-, гуул-, гонжсоол-, гүцэл-, лаазал-, лонхол-, манхагла-, маюузал-, савла-, сагсал-, сэгсэл-, шуудайл-, суваргал-, сугсуйл- (дугтуйнд агуул-), сөгнө-, шуумсал-, тавагла-, тавсагла-, таарла-, таарцагла-, тэвшил-, туламла-, түнгэрцэглэ-, даамна- (гар алчуураа даамнах), даалинла-, дэвэрлэ-(дэвэрт агуул-), дугтуйл-, дүүрэглэ-(саваа дүүргэх), цэнэглэ-, чандруул- (саванд дүүрэн агуулах), чих-, чигж-, цогцол-, зүүвчил-, зоорил-, хүлх-, хамар-” (Да.Баа.-1992, 12-14-р т.) зэрэг үгсийг голч утгаар иж үг хэмээн үзсэн нь “зүйлчилсэн үгс”-ийг багтаасан ба “агуул-, хүлх-, хамар-, үй-, үмх-, хий-, чих-, чигж-” зэргийг ялгаж, улмаар “агуулах” гэсэн гол үгтэй “хураа-, нөөцөл-, хадгал-, цуглуул-, нөө-” зэрэг үгс нь ойролцоо утгатай болно. Үүнд “нөө-, нөөцөл-, хадгал-” гэхэд “хожим хэрэглэхийн тул гамнах, хэмнэх” гэсэн утгаараа нийлсэн бол “нөө-” нь “уг юмаа гамнах” гэсэн нэг үйлдэл бүхий утгатай бол “нөөцөл-” гэхэд “нөөц болгон хадгалах” гэсэн олон үйлдэл бүхий утгатай юм. Тэгвэл “хадгал-” гэдэг нь “нөөж, далдлах” гэсэн утгаараа өмнөх “нөө-, нөөцөл-”-өөс ялгарна.

Ю.Д.Апресян орос хэлний “Расстояние между ними уменьшилось (сократилось) вдвое” хэмээх өгүүлбэр дэх “уменьшилось, сократилось” гэсэн гишүүнийг явцуу хүрээн дэх үгийн түвшний ойролцоо нэгж болно (Ю.Д.Ап.-1969, 76-р т.) гээд, хэлний ойролцоо нэгжийг өргөн хүрээгээр үзвэл, 1) язгуур бүтээвэр нь хэвээр үлдэж, үг бүтээх ба үг хувилгах, үгийн байрлалыг солих зэрэг нь өгүүлбэрийн хувиргал:

Я не хочу, чтобы он уходил. - Я хочу, чтобы он не уходил.

Я предлагаю вам уйти. - Я предлагаю, чтобы вы ушли.

2) Өгүүлбэр дэх үгийг сольж, ойролцоо өгүүлбэр бүтээх, үүнд:

а) хөрвөл. *Бутылка влишает три литра. - В бутылку входит три литра.*

б) эсрэг утга: *сомневаться - не быть уверенным, помнить- не забывать*

в) төрөл зүйлийн утга: *карты-карточная игра, шептать-говорить шепотом*

г) үүсмэл үгээр: *Он помогает мне-Он оказывает мне помощь.*

д) үгийг анхдагч утгаар: *Он ушел по моему совету- Он последовал моему совету уйти.*

е) утгыг хураах: *обесмысливать- лишать смысла, Кроме него никто не пришел- Он был единственным, кто пришел*” гэсэн ойролцоо нэгж байж болно гэж үзсэн байна.

Үгийн түвшний нэг ай болох ойролцоо үгс нь “элэг-лэ-, доог-ло-, шоо-л-; эмх-л-, цэгц-л-, багц-л-, янз-л-, цоож-л-, цуурга-л-; хэрэг-лэ-, эд-л-;хурд-(н)-л-, түргэ-(н)-л-, үтэр-лэ-, шалав-ла-, бушуу-л-; худалдаа-л-, наймаа-л-, арилжаа-л-; хөлс-л-, ацаг-л-; хориг-л-, цээр-лэ-, цааз-л-; хоол-ло-, цав-ла-; хязгаар-ла-, зах-л-; зааг-ла-, хил-лэ-; хариу-л-, адуу-л-; хашир-ла-, хэрсүү-л-, хашир-ж-, хэрсүү-ж-; хар-д-, сэр-д-; хурд-д-, түргэ-д-; үлгэр-лэ-, жишээ-л-; ухаа(н)-р-, сэхээ-р-, аахь-л-, уухь-л-; уур-ла-, хилэн-нэ-; тэнэг-лэ-,

мунхаг-ла-; тэнэг-т-, мулгуу-т-; төвөг-шөө-, тээр-шээ, тойв-шоо-; яршиг-ла-, ярвиг-ла-; тус-л-, нэмэр-лэ-, хандив-ла-; том-рх-, их-рх-; толгой-л-, тэргүү-л-; тойм-л-, багцаа-л-, бараг-цаал-; хураангуй-л-, товчоо-л-, товч-л-; тарга-л-, мариа-л-; андгай-л-, тангараг-ла-; таг-ла-, халби-л-, хавхаг-ла-; тав-ла-, тух-л-; таавар-ла-, таамаг-ла-; сул-ла-, задгай-л-; сони-(н)-рх-, хачи-(н)-рх-; хориг-ло, тоггор-ло-; өлгий-л-, манцуй-л-; нэвт-л-, шувт-л-; дотно-л-, шадар-ла-; нүцгэ-(н)-л-, шалд-(н)-л-; нөхөр-л-, найз-л-, хань-л-; таа-р-, тохь-р-; ний-ц-, зохь-ц-; мэх-л-, заль-л-, ов-ло-; ич-үүр (ич-гүүр), сонж-уур; их-нх, олон-х, дийл-нх; илэр-хий, тодор-хой; ил-р-, тод-р-; ид-тэн-, шид-тэн-; зүг-лэ-, чиг-лэ-; зөрүү-д, гажуу-д, гэжүү-д; зориг-ло-, зүрх-л-; зах-л-, хөвөө-л-, ирмэг-лэ-; зам-чин, газар-чин; замч-л-, газарч-л-; журам-ла-, горим-ло-; жолоо-д-, залуур-д-; далд-л-, нууц-л-, битүү-л-; гэрч-л-, баримт-л-; гөр-д-, гүжир-д-; ганц-д-, нэг-д-; гадар-ла-, өнгө-л-; бэрх-д-, хэцүү-д-; гадар-ла-, төсөө-л-; бөөгнө-р-, шаваа-р-, овоо-р-, багш-р-; бөх-л-, бэх-л-; бат-л-, нут-л-(нот-л-); бар-д-, эр-д-, барь-уу, давч-уу; байр-ла-, оро(г)-но-; ая-л-, эгшиг-лэ-; баа-гь-, уу-гь-; бага-д-, жижиг-д-; ая-(н)-л-, зам-на-, жуулчи(н)-л-; атаа-рх-, жөтөө-рх-; арви-л-, гам-на-, хэм-нэ-; ан-чин, гөрөө-чин, ав-чин; арч-л-, ариг-ла-; анх-л-, тэргүү-л-; зүйр-лэ-, үлгэр-лэ-; агт-л-, хөнгө-л-; агт-чин, адуу-чин; ан-на, ав-ла-, гөрөө-л-; ааш-л-, аяг-ла- гэх зэргээр ойролцоо нэр үйлийн үгсэд нэг дагавар залгавал мөн л ойролцоо үг үүсэж байна. (Б.Ид.-2005, 10-р т.) Дээр дурдсан Да. Баатараас “агуулах” гэсэн толгой үгнээ “агуулагдахуун агуулахуун” хоёрын харьцаат үгсийг нэрээс үйл үг бүтээх “-л” дагавраар нэгтгэсэн нь харахан ойролцоо биш юм. Гагцхүү тухайн эхэд “Улсын хөрөнгийг мөн ч ууталж байна даа” гэхэд орсон “уут-л-” гэснийг “хүүдий-л-, гүзээ-л-, тулам-ла-, шуудай-л-” гэх зэрэг үгсээр сольж болох нь Ю.Д.Апресяны үзсэнээр “хуурмаг ойролцоо үгс” (квазисинонимы) буюу найруулгын ойролцоо үг болно. Учир нь, хуурмаг ойролцоо үгийн агуулга буюу тайлал нь өргөн хүрээтэй бөгөөд утгаараа бүрэн тохирдоггүй (Ю.Д.Ап.-1969, 89-р т.) ба “Иймд оновчтой буюу жинхэнэ ойролцоо үг нь утгаараа төдий л ялгарахгүй, ойр утгын үүр эгнээ гэх юм байдаггүй бол хуурмаг ойролцоо үгс нь утгаараа нарийн ялгарах учраас утгын тодорхой бүтцийг бий болгодог. Энэ бүтэц нь хоёр янз. 1-рт, ойролцоо үүр үгс нь хэд хэдэн хэсэг болж, ойролцоо үгсийн эгнээг бий болгож, шатлан мөчирлөсөн дээд түвшдэд хуваарилагдан ордог... 2-рт, хуурмаг ойролцоо үгс нь дэд анги буюу хоршоо үг болтлоо задрахдаа нэг нь нөгөөтэйгээ сүлжсэн мэт байдаг. Зүйл зүйлийн хуурмаг ойролцоо үгс нь хэд хэдэн утгын бүлэг үүсгэж бие биеэсээ ялгардаг” (Ю.Д.Ап.-1974, 249-р т.) гээд орос хэлний “*бить*” хэмээх үг нь хүчин чадал ба хэрэглүүрийн утгаар задарч, улмаар цааш бага бага зүйлийн утгаар ялгарах тухай бичжээ. “Агуулахуун-агуулагдахуун”-ы утгыг *а. чигж-, хий-, үй-, нэр-, цэнэглэ- а. чигж-... б. нэр- (а. нэр-, б. цэнэглэ-, в. ховдогло-, гэдэслэ-) в. савла-, хундагал-, хавтагал- (а. савла-... б. пансал-, в. хүлх-, г. хамар-)* гэх мэтээр “их-их, бага-бага, их-бага” гэх мэтээр зүйлчлэн ангилж болно. Иймээс Да. Баатарын “иж үгс” гэдэг нь утгын зүйлчлэл болох ба үүнээс хуурмаг ойролцоо үгийг ялгах хэрэгтэй ба зүйлийн үгс нь ойролцоо утгын холбоо байдаггүй. Жишээ нь: орос хэлний “*величина вес, вместимость, высота, глубина, длина, интенсивность, количество, объем, площадь, размер, рост, сила, скорость, температура, толщина, число, ширина, яркость (горячий, теплый, холодный, нагреваться, охлаждаться, расколять, брезги, детали, капли, комья, крошки, куски, ломти, лоскуты, обрезки, обрывки, осколки, отрывки, фрагменты, части, шепки)* зэрэг юмс үзэгдлийн 1. чанар, 2. тоо, 3. цаг, 4. орон гэсэн хийсвэр айн үгс нь зүйлийн үгс болно. Тэгвэл Да. Баатарын дээрх үгс нь зүйлчлэл болохоос, хуурмаг ойролцоо үгс

биш юм. (Ю.Д.Ап.-1974, 251-252-р т.) Н.Ю.Шведова ойролцоо үгийг тайлал тайлбараар, тухайлбал, монгол хэлний *“ялгаа зөрөө, охь манлай, бардам сагсуу, уг үндэс, үндэс язгуур, ангах цангах, удирдах жолоодох, үймээн шуугиан, үнэнч шударга, итгэх үнэмших, мөхөх сөнөх, үзэх харах, далд нууц, хичээх мэрийх, мэрийх чармайх, бутрах сарних, бүх нийтээрээ, бишүүрхэх ичих, халах солих, гоё ганган, магтах сайшаах, судлах шинэжлэх, зодох нүдэх, яарах бачимдах, хэлэх ярих, эрт урьд, харгис хэрцгий, үсрэх харайх, хахирах бархирах, орилох чарлах, элэгсэг дотно, асуух сурах”* зэрэг хоршоо үгийн нэг нь нөгөөгийнхөө утгыг тайлбарлан, оновчтой буюу жинхэнэ ойролцоо үг бүтээдгийг тийм ч оновчтой биш гэж Ю.Д. Апресяны санааг шүүмжилжээ. Учир нь, ойролцоо үгийг нэг болохоороо ерөнхийлөөд, нөгөө болохлоороо нарийвчилсан байна. (Н.Ю.Шве.-1970, 37-р т.) Жишээ нь: орос хэлний *“возрастать”* (начинать быть больше)-*увеличиваться* (тоже значение), *автор* (тот, кто создал нечто)-*создатель* (тоже значение), *за мужем* (состоящий в браке)-*женат* (тоже значение) гэсэн үгсийн утга ойр буй нь хэт ерөнхий, *“давить”* (прилагать к участку поверхности предмета силу, изменяющую его положение и форму; активная сила направлена с одной стороны)-*жать* (прилагать к участку поверхности предмета силу, изменяющую его положение и форму; активная сила направлена с разных сторон) гэсэн үгсийн ойр утга нь дэндүү нарийвчилжээ гээд, тэрээр, жинхэнэ ойролцоо үгийг хуурмаг ойролцоо үг болгож ч мэднэ. Бас заримд нь тайлбар илүүдэж, нөгөөд нь дутжээ” гэсэн байна. Үүнээс үүдэн Н.Ю. Шведова зарим утгыг санаанаасаа тайлбарласан, жинхэнэ ба хуурмаг ойролцоо үгийг ялгахгүйд хүрсэн, үгийн утга, утгын зохицол хоёрыг ялган үзэх (утга зохицохыг хэт өргөсөн), утгын зохицол нь хатуу хязгаартай байдаг” гэсэн нь үндэс муутай болсон. (Жишээ нь, *“катастрофа”* гэсэн үг нь “несчастный случай на транспорте” гэж зөвхөн тэмдэг нэртэй зохицно гэсэн нь дутмаг юм. Гэтэл *“катастрофа с самолетом”* гэж утгын зохицол гарах ажээ) Зарим үгсийн утгын тодорхой зохицлыг бүрхэг болгож, бүрэн гаргаагүй, хэлц ба хэлц бус үгсийн зохицол адилгүй болохыг анхаарах, үгийн утгыг хувийн ойлгоцоор гаргаж болохгүй (Жишээ нь, *“скупой”* гэдгийг “сильно не желающий утратить X, который у него есть и который не является для него необходимым) гэсний сүүлчийн хэсэг нь буруу юм) гэсэн 8 зүйлээр шүүмжилжээ (Н.Ю.Шве.-1970, 37-44-р т.) Үүнд хариу болгож, Ю.Д. Апресян мөн найман зүйлээр тайлбарлажээ. Тухайлбал, орос хэлний *“увеличиваться-возрастать”* гэхэд Н.Ю. Шведова “становиться больше в объеме, размере” гэж тайлбарласныг Ю.Д. Апресян энэ үгэнд “багтаамж” (объем) гэх үг илүүц болжээ гэж үзсэн байна. 8-р зүйлд үгийн утгыг хувь ойлгоцоор тайлбарлаж болохгүй гэсэн түүний шүүмжид Л.В. Щербагаас “туршилтанд хэлний хэрэглэгдэхүүнд үл таарах санаа төрж, үгийн утгын чухал махбодыг тогтоож болно” гэсэн үгээр хариу барьсан бол 5-р зүйлд “катастрофа с самолетом” гэдгийг орхисон гэсэн бол Ю.Д. Апресян “авиационная катастрофа” гэж тодотгож болно гээд, ер нь хэлэнд “хязгаарлах ба эс хязгаарлах, боломжит ба боломжит бус, зөв ба буруу, хэвийн ба гажсан зүйлс арвин байдаг гээд *“нервно держала правую руку”, “Открытая буланая машина”, “Поразил ворота команды Польши”* гэх мэт жишээ татжээ. (Ю.Д.Ап.-1974, 24-р т., 32-р т.)

(Үргэлжлэл бий)